

**ИРГЭНИЙ БОЛОН УЛС ТӨРИЙН ЭРХИЙН
ТУХАЙ ОЛОН УЛСЫН ПАКТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ
МОНГОЛ УЛСЫН ЭЭЛЖИТ ЗУРГАА ДАХЬ ТАЙЛАН
/2015 он/**

Энэхүү тайланг Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 40 дүгээр зүйл болон НҮБ-ын Хүний эрхийн хорооны шийдвэрийн дагуу өргөн барьж байна. Тус тайлангийн зарим мэдээллийг Хорооноос зөвлөмж болгосон асуудлуудад анхаарлаа хандуулан мэдээллийг дэлгэрэнгүй байдлаар орууллаа.

I ХЭСЭГ

1 дүгээр зүйл. Бүх ард түмэн өөрөө засан тохинох эрхтэй.

Монгол Улс нь 1992 онд батлагдсан Үндсэн хуулиар парламентын бүгд найрамдах улс мөн. Монгол Улсад төрийн эрх мэдлийн хуваарилалт дараах байдлаар хуваарлигдсан байдаг. Үүнд: хууль тогтоох дээд байгууллага нь Улсын Их Хурал, гүйцэтгэх дээд байгууллага нь Засгийн газар, шүүх эрх мэдлийн дээд байгууллага нь Улсын дээд шүүх болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлд зааснаар “Монгол Улс бол тусгаар тогтносон бүрэн эрхт Бүгд Найрамдах Улс” юм. Монгол Улс нь өөрийн дотоод, гадаад бодлогоо гадны ямар нэг улс орны шууд болон дам оролцоогүй өөрөө бие дааж, бодитой хэрэгжүүлдэг бөгөөд олон улсын харилцаанд аль ч улсаас хараат бусаар оролцох бүрэн чадамжтай болно.

Мөн Монгол Улс нь төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улс болно. Хууль тогтоох эрх мэдлийг дангаараа хэрэгжүүлэх бүрэн эрх бүхий төрийн эрх барих дээд байгууллага нь Улсын Их Хурал юм. Улсын Их Хурал нь 76 гишүүнтэй бөгөөд Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж 4 жилийн хугацаагаар сонгодог.

Монгол Улсын Засгийн газар нь төрийн гүйцэтгэх дээд байгууллага юм. Засгийн газрыг Улсын Их Хурлаас байгуулдаг ба түүнийг сонгуульд ялсан улс төрийн намын дарга нь Ерөнхий сайдаар сонгогдон, төрийн хуулийг хэрэгжүүлэх ажлыг хариуцан гүйцэтгэдэг.

Монгол Улсын төрийн тэргүүн нь Монгол Улсын Ерөнхийлөгч юм. Ерөнхийлөгчийг хоёр шаттай сонгуулиар сонгох бөгөөд анхан шатны сонгуульд Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхтэй оролцож, Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн талаар саналаа нууцаар гаргаж сонгоно. Хоёр дахь шатанд сонгогчдын олонхийн санал авсан нэр дэвшигчийг УИХ-аар баталдаг. Монгол Улсын Ерөнхийлөгч нь Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн үүргийг гүйцэтгэдэг

Монгол Улсад шүүх эрх мэдлийг зөвхөн Үндсэн хуулийн дагуу байгуулагдсан шүүх хэрэгжүүлдэг. Шүүгч хараат бус байж зөвхөн хуульд захирагдан үйл ажиллагаагаа явуулдаг. Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг Шүүхийн ерөнхий зөвлөл хариуцдаг.

Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй бөгөөд Монгол Улсын хилийг хуулиар бататгана. Монгол Улс өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчинтэй. Төрийн албан ёсны хэл нь монгол хэл юм.

“Монгол Улсад төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдэлнэ” гэж Үндсэн хуулинд заасан бөгөөд Монгол Улсад шашин сүм хийдийн харилцааг хуулиар

зохицуулдаг ба төр шашны тус тусын хэрэгт үл оролцох зарчим, иргэдийн шүтэх, эс шүтэх эрх чөлөөг баталгаажуулж, шашны урсгалууд орж ирэх нөхцөлийг хангасан болно.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсад Будда, Христ, Ислам, Бахай, Бөө мөргөл, Мүүн (600 гаран шашны урсгал) шашны 692 байгууллагууд бүртгэгдэн ажиллаж байна.

II ХЭСЭГ

2 дугаар зүйл. Хүний эрхийг ялгаварлахгүйгээр хүндэтгэн хангах үүрэг

Монгол Улс тайлангийн хугацаанд:

- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын Цаазаар авах ялыг халахад чиглэсэн нэмэлт II протоколд (2012) нэгдэн орж,
- Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенц (2014)-ийг соёрхон батлаж,
- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн нэмэлт протоколыг (2014) мөн соёрхон батлав.

Мөн хугацаанд батлагдсан Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Тахарын албаны тухай хуулийн дагуу гэрч, хохирогчийг хуульд заасан хэлбэрээр хамгаалах үүрэг бүхий Тахарын албыг шинээр байгуулан ажиллуулж байна. Тахарын алба нь 79 шүүхийн 41 Тамгын газрын 43 байрыг хамгаалалтанд аваад байна.

Хүний эрхийн чиглэлээрх олон улсын гэрээнд нэгдэн орох, орсон гэрээний хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, гэрээний тайлан, мэдээллийг боловсруулах, хүргүүлэх ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий Хүний эрхийн хэлтсийг Гадаад хэргийн яамны Олон улсын эрх зүйн газарт 2014 онд шинээр байгуулав.

1992 онд батлагдсан Монгол Улсын шинэ Үндсэн хууль дэлхий нийтийн жишигт нийцсэн эрх, эрх чөлөөг эдлэх боломжийг ард иргэдэд олгосон бөгөөд эдгээр үндсэн эрхийн нэг нь хууль зүйн туслалцаа авах эрх болохыг тодорхой зааж өгсөн.

Монгол Улс зах зээлийн эдийн засагтай, ардчилсан нийгэмд шилжсэнээр аливаа салбарын мэргэжлийн ажил, үйлчилгээ нь чөлөөт өрсөлдөөнд суурилан өөрөө өөрийгөө санхүүжүүлэх болсны нэг нь өмгөөлөл, хууль зүйн үйлчилгээ гэж хэлж болно. Энэ нь нэг талаас тухайн салбарыг хөгжүүлэх гол хүчин зүйл боловч нөгөө талаасаа, хөрөнгө, санхүүгийн бэрхшээлтэй, төлбөрийн чадваргүй иргэд хууль зүйн туслалцаа, дэмжлэг авч чадахгүйн улмаас эрх нь зөрчигдөх, цаашилбал, нийт улсын хэмжээний хууль зүйн үйлчилгээний хүртээмж хумигдан, хязгаарлагдах сөрөг үр дагаврыг дагуулах болсон.

Иймд төрөөс энэ асуудлыг анхааран үзэж иргэдийнхээ эрхийг хамгаалах талаар холбогдох арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлсээр байна. “Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх Үндэсний хөтөлбөр”-ийг Засгийн газрын 2006 оны 263 дугаар тогтоолоор батлан, 2007-2012 онуудад хэрэгжүүлсэн.

Уг хөтөлбөрийг хэрэгжүүлсэн туршлага, хүний нөөц, материаллаг баазад түшиглэн төлбөрийн чадваргүй иргэнд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлын эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлаас Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль 2013 оны 07 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан. Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяанд төлбөрийн чадваргүй яллагдагчид үнэ

төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий төрийн байгууллага болох Хууль зүйн туслалцааны төв байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна.

Ажлын албанд 13, салбарт 50 улсын өмгөөлөгч, 9 улсын өмгөөлөгчийн туслах, нийт 72 албан хаагчид ажиллаж байна. Тус төвийн орон нутгийн дийлэнх салбарууд тухайн аймгийн Засаг даргын Тамгын газрын ажлын байрыг түшиглэн ажилладаг бөгөөд тухайн орон нутгийн гэмт хэргийн гаралтаас шалтгаалан улсын өмгөөлөгчийн тоо салбар бүрт харилцан адилгүй буюу нэг салбарт 1-4 улсын өмгөөлөгчийг томилон ажиллуулдаг.

Хууль зүйн туслалцааны төвийн салбарын улсын өмгөөлөгчид 2014 оны жилийн эцсийн байдлаар нийт **7351** иргэнд хууль зүйн зөвлөгөө өгч, **1895** хэргийн 2102 холбогдогчид өмгөөллийн үйлчилгээ үзүүлсэн. Үүнээс насанд хүрээгүй хүүхэд **142**, харьяалалгүй хүн болон гадаадын иргэн **5** байсан.

Монгол улсын хэмжээнд 2014 онд 6375 эрүүгийн хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэнээс 1895 хэргийн 2102 холбогдогч үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авсан байна. Энэ нь шүүхээр шийдвэрлэгдсэн нийт эрүүгийн хэргийн 30%-д нь улсын өмгөөлөгчид өмгөөллийн үйлчилгээ үзүүлсэн тоо баримт болж байгаа юм. Монголын Хуульчдын холбооноос авсан мэдээллээс үзэхэд улсын өмгөөлөгчид нийт өмгөөлөгчдийн 2.5%-ийг эзэлж байгаа болно. Өөрөөр хэлбэл, нийт шүүхэд төлөөлөх эрхтэй хуульчдын 2.5%-тай тэнцэх тооны улсын өмгөөлөгч улсын хэмжээнд шүүхээр шийдвэрлэгдсэн нийт эрүүгийн хэргийн 30%-д нь орж ажилласан байна.

Мөн 2015 оны эхний хагас жилд тус төвийн салбарын улсын өмгөөлөгчид нийт **4059** иргэнд хууль зүйн зөвлөгөө өгч, **1763** хэргийн **1903** холбогдогчид өмгөөллийн үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнээс насанд хүрээгүй хүүхэд **140**, харьяалалгүй хүн болон гадаадын иргэн 6 байна.

3 дугаар зүйл. Иргэний болон улс төрийн бүх эрхийг эрэгтэй, эмэгтэйчүүдэд тэгш эдлүүлэх үүрэг

“Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль”-ийг 2011 онд баталсан. 2012 онд шинэчлэн баталсан “Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль”-д нам, эвслээс УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийн 20-иос доошгүй хувь нь эмэгтэйчүүд байхаар тусгасан. УИХ-ын 2012 оны сонгуульд нэр дэвшигчдийн 32 хувь нь эмэгтэйчүүд байсан бөгөөд сонгогдсон нийт 76 гишүүний 14.47 хувь нь буюу 11 эмэгтэй гишүүн байгаа нь өмнөх Парламент дахь эмэгтэй гишүүдийн тооноос 4 дахин их байна. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд яам, агентлаг болон орон нутгийн удирдлагын байгууллагад эмэгтэйчүүдийн төлөөлөл бүх түвшинд 15-40 хүртэлх хувиас доошгүй байхаар заасан. Төрийн захиргааны албанд нийт 17.9 мянган албан хаагч ажиллаж буйн 57.4 хувь нь эмэгтэй байгаагаас 27.6 хувь нь ахлах албан тушаал хашиж байна.

Монгол Улсад охид, хөвгүүд, эмэгтэй, эрэгтэйчүүд нь бага боловсрол, бүрэн дунд, дээд, тусгай мэргэжлийн болон шинжлэх ухаан, технологийн гэх зэргээр бүхий л салбарт боловсролыг тэгш хүртэх боломжийг бүрдүүлсэн. Монгол Улсын Засгийн газар Боловсрол шинжлэх ухааны яамны дэргэд насан туршийн боловсролын төвийг байгуулан ажиллаж байна. Хуульд зааснаар охид, хөвгүүд, эмэгтэй, эрэгтэйчүүд боловсрол тэгш хүртэх боломжийг хангасан бодлогын хэрэгжилт, чанар үйлчилгээ, үйл ажиллагаанд нь мэргэжлийн хяналтын боловсролын байцаагчид хяналт тавьж ажилладаг.

Хууль зүйн яам, төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудад оролцоонд суурилсан жендэрийн үнэлгээ, жендэрийн асуудлыг ойлгох, салбарын бодлогот

жөндөрийн үзэл баримтлалыг нэвтрүүлэхэд туслахаар 2015 онд энэхүү жөндөрийн үнэлгээг хийсэн.

4, 5 дугаар зүйл. Онц байдлын үед хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах хэмжээ

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө” гэж заасан бөгөөд энэ заалт Онц байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлд тусгагдсан.

Мөн онц байдал зарласан үед гадаад харилцааны асуудал эрхэлсэн Монгол Улсын сайд онц байдлын үед Монгол Улс Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактаар хүлээсэн үүргээс татгалзахад хүргэсэн хүний эрх, эрх чөлөөг хязгаарлахтай холбогдсон ямар онцгой арга хэмжээг, ямар үндэслэлээр авч хэрэгжүүлэхээр тогтоож байгаа болон түүнийгээ хэдийд цуцлах тухайгаа Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад нэн даруй мэдээлэх журмыг хуулиар тогтоосон.

Монгол Улсын түүхэнд ганцхан удаа Ерөнхийлөгч онц байдал зарласан байдаг. Энэ нь 2008 оны долдугаар сарын 01-нд үүссэн үймээний улмаас эмх замбараагүй байдал бий болж, үйл явдал холбогдох байгууллагын хяналтаас гарч эхлэх үед зарласан Ерөнхийлөгчийн зарлиг билээ. Зарлигт “2008 оны долдугаар сарын 01-ний өдөр нийслэлийн Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт бүлэг хүмүүс хүч хэрэглэсэн хууль бус үйл ажиллагааны улмаас нийтийн эмх замбараагүй байдал үүсч, хууль сахиулах байгууллагын ажилтнуудад халдан амь насанд нь заналхийлж, эд хөрөнгө устгах, галдан шатаах үйл ажиллагаа даамжирч, нийтийн эмх замбараагүй байдал бий болсон тул энэхүү онцгой нөхцөл, үр дагаврыг арилгах, хүн ам, нийгмийн амьдралыг хэвийн болгох зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 12-т заасан бүрэн эрхийнхээ дагуу, Онц байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 болон 6 дахь хэсгийг баримтлан нийслэл Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт 2008 оны долдугаар сарын 01-ний өдрийн 24.00 цагаас эхлэн 4 хоногийн хугацаанд онц байдал зарласугай” гэжээ. Онц байдлыг зарласан хугацаанд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсүгэй. Улсын онц чухал болон хүн амын амьжиргааны хангамжийн объектуудыг хүч нэмэгдүүлэн хамгаалах.

1. Хууль тогтоомж зөрчиж зохион байгуулсан жагсаал, цуглаан, олон нийтийн бусад арга хэмжээг хуульд заасан арга, хүч хэрэгслээр шууд албадан тараах.
2. Улаанбаатар хотын төвийн хэсэгт тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах, тэдгээрт үзлэг хийх.
3. Нийтийн эмх замбараагүй байдал бий болгож, хүч хэрэглэсэн үйл ажиллагаа явуулсан буюу явуулж байгаа бүлэг хүмүүсийг албадан тараах, албадан саатуулах, тэдгээрийн зэвсэг, техник хэрэгслийг хураан авах.
4. Улаанбаатар хотын төвийн хэсэгт /Бага тойруу/ 22.00-08.00 цагийн хооронд хөл хорьж, зөрчсөн этгээдийг цагдаа буюу цэргийн эргүүл хөл хорих цаг дуустал, иргэний үнэмлэх, түүнтэй адилтах баримт бичиггүй бол хэн болохыг нь тогтоох хүртэл, гэхдээ 72 цагаас илүүгүй хугацаагаар албадан саатуулах.
5. Дуу авиаг чангаруулах техник хэрэгслийн ашиглалтыг хориглох шаардлагатай бол түр хураан авах, Үндэсний олон нийтийн радио, телевизээс бусад телевизийн үйл ажиллагааг онцгой байдлыг цуцлах хүртэл зогсоох.

6. Сogтууруулах ундааний зүйл худалдах, тараахыг хориглох.
7. Иргэдийн эзэмшилд байгаа гал болон хүйтэн зэвсэг, галт хэрэгсэл, аж ахуйн нэгж байгууллагын үйлдвэрлэлийн технологиуд хэрэглэдэг тэсэрч дэлбэрэх, хүчтэй үйлчлэх химийн хорт болон цацраг идэвхт бодис, сургалтын зориулалттай байлдааны зэвсэг, техник хэрэгслэлийн ашиглалтад хяналт тогтоох.
8. Энэхүү зарлигийг хэрэгжүүлэхэд шаардагдах арга хэмжээг Онц байдлын тухай хууль болон бусад хуулийн хүрээнд холбогдох байгууллагуудын хүч хэрэгслийг дайчлан удирдан зохион байгуулж, ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд /Ц.Мөнх-Оргил/-д үүрэг болгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 194 тоот зарлиг гарч, Улаанбаатар хотод 4 хоногийн хугацаатай онц байдал тогтоож энэ тухай Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Гадаад хэргийн сайд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад ноот бичгийг илгээсэн байдаг.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2010 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 173 дугаар тушаалаар “Онц байдал зарласан үед нийгмийн хэв журам хамгаалах” журам /код 416/-ыг баталсан. Журамд цагдаагийн байгууллага, алба хаагч нь онц байдлын үед үүргээ хэрэгжүүлэх явцад хүний эрх, эрх чөлөөг хязгаарлахдаа хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хангаж, хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус хэрцгий хандахыг хориглоно гэж заасан. Цагдаагийн байгууллагаас Онц байдал зарласан үед гүйцэтгэх үүргийг нэг бүрчлэн тодорхойлсон байдаг.

Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үзэл баримтлалыг үндэслэн Хохирогчид нөхөн олговор олгох тухай хуулийг Монгол Улсын Их Хурал 2009 оны 07 дугаар сарын 09-ний өдөр баталсан. Хууль батлагдснаас хойш хохирогчдын нөхөн олговор зориулж улсын төсвөөс 17,1 тэрбум төгрөг зарцуулсан байна. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 294 дүгээр тогтоолын дагуу нөхөн олговор олгох болсонтой холбогдуулан 2008 оны нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үеэр албан үүргээ гүйцэтгэж байхдаа гэмтэж бэртсэн 396 цагдаагийн алба хаагчдад 442.5 сая төгрөгийн нөхөн олговор олгуулах ажлыг зохион байгуулсан.

Эрүүл мэндийн яам болон Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга нарын хамтарсан удирдамж, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2011 оны 254 дүгээр тушаалаар 2008 оны 07 дугаар сарын 01-ны өдөр болсон нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үеэр бэртэж, гэмтсэн цагдаа, дотоод цэргийн алба хаагчдад нэгдүгээр шатны эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулж, 258 алба хаагчийг хамруулсан.

III ХЭСЭГ

6 дугаар зүйл. Хүн бүр амьд явах салшгүй эрхтэй.

Монгол Улс нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II дугаар Протоколд нэгдэж орсонтой холбогдуулан цаазаар авах ялыг бүрмөсөн хална. Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад энэ онцгой ялын оронд бүх насаар хорих ялыг хуулийн төсөлд тусгаж, 25 жилийн дараа тодорхой болзол хангаж байвал хугацаатай хорих ялаар сольж болох талаарх зохицуулалтыг шинээр тусгасан.

Хорих ял нь хугацаатай ба бүх насаар хорих гэсэн хэлбэртэй байна. Хугацаатай хорих ял нь долоо хоногоос хорин жил хүртэл, бүх насаар хорих ял нь хорин жилээс дээш хугацаагаар байх бөгөөд суллагдах үндэслэл нь хорин таван жилээс дээш хугацаагаар хорих ялыг биечлэн эдэлсний дараа үүсэхээр заасан.

7 дугаар зүйл. Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус хэрцгий хандахыг хориглох

Монгол Улс “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг НҮБ-ын конвенцийн Нэмэлт Протокол”-д 2013 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр гарын үсэг зурж, 2014 оны 12 дугаар сарын 11-ний өдөр соёрхон баталсан.

2013 онд батлагдсан Цагдаагийн албаны тухай хуулиар цагдаагийн алба, албан хаагчийн үйл ажиллагаанд хяналт тавих эрхийг ХЭҮК-т олгосон. Ингэснээр цагдаагийн албан хаагчийн үйл ажиллагаанд хяналт тавих хараат бус үндэсний тогтолцоо бүрдэж байна. Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг цагдаагийн байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх, түүний биелэлтийг хангуулж, дээд шатны байгууллагад танилцуулах үүрэг бүхий салбар хороог байгуулсан. Цагдаагийн ерөнхий газрын тэргүүн дэд даргаар ахлуулсан тус салбар хороо нь хүний эрхийг хангах ажлын хүрээнд болон “Цагдаагийн ерөнхий газар болон Хүний эрхийн үндэсний комиссын хамтран ажиллах санамж бичиг”-ийн хүрээнд зохион байгуулсан ажил, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, эрүүгийн хэрэгт цагдан хоригдсон хүмүүсийн талаарх судалгаа, цагдан хоригдсон сэжигтэн, яллагдагч нараас хүний эрхийн талаар гаргасан гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлт болон цаашид хүний эрхийг хангах ажлын хүрээнд дэвшүүлэх зорилт, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хэлэлцсэн хурлыг зохион байгуулж хэвшсэн.

Цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бүтцээр Гэмт хэрэгтэй тэмцэх газрын Мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх мэргэжлийн газрын Тусгай субъектын үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах хэлтсийг, Цагдаагийн ерөнхий газрын дотоод хяналт-аюулгүй байдлыг хангах газарт шилжүүлэн байгуулсан. “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам”-ын код 224-д “Цагдаагийн алба хаагч түр саатуулагдсан этгээдтэй хэрцгий хүнлэг бусаар, басамжлан доромжилж харьцах, бие махбодь сэтгэл санааг шаналган зовоох аливаа санаатай үйлдэл хийх зэргээр эрүүдэн шүүж, зүй бусаар харьцахыг хориглоно” гэж заасныг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн нэгдсэн мэдээгээр Эрүүгийн хуульд заасан эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт 2010-2014 онд 2010 онд 1 хэрэгт 1 хүн (Баян-Өлгий аймагт), 2013 онд 1 хэрэгт 1 хүн (Хөвсгөл аймагт), 1 хэрэгт 2 хүнд (Дорнод аймагт) тус тус Эрүүгийн хуулийн 251 дүгээр зүйл ангиар ял оногдуулсан байна. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхтэй холбоотойгоор Прокурорын байгууллагаас шаардлага, албан даалгавар цагдаагийн байгууллагад ирүүлээгүй байна.

Мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх мэргэжлийн газрын уулзалт байцаалтын хэсгийг дүрс бичлэгээр бүрэн тоногосноор хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч, тагнуулын болон авлигатай тэмцэх газрын мөрдөн байцаагч нар сэжигтэн, яллагдагчтай уулзах, байцаалт авахдаа байцаан шийтгэх ажиллагааны оролцогч нарын аюулгүй байдал хангагдаж, хяналт хамгаалалт, нууцлал, дэг журмыг сахиулах ажиллагаа сайжран, эрүүдэн шүүх, хүнлэг бус харьцах тохиолдол 2014 онд гараагүй байна.

Олон улсын жишигт нийцсэн цагдан хорих 6 байрыг 2007-2011 онд ашиглалтад оруулж, 12 аймаг дахь Шийдвэр гүйцэтгэх албадын Цагдан хорих байрны их засварын ажлыг бүрэн хийж дуусгасанаар хорих байрны ахуй нөхцөл харьцангуй дээшилсэн. Хорих байгууллагын нөхцөлийг НҮБ-ын жишигт хүргэх чиглэлээр 2013 онд шинээр 5 стандарт батлан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад "...бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх..." гэж хохирол нөхөн төлүүлэх эрхийг баталгаажуулсан.

Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.4 дэх хэсэгт "Хууль бусаар яллагдагчаар татагдсан, ял шийтгүүлсэн, баривчлагдсан, саатуулагдсан буюу гадагш явахгүй гэсэн баталгаа өгсөн, захиргааны журмаар баривчлагдсан этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээсэн тохиолдолд түүнд учирсан хохирлыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор болон шүүгчийн буруутай эсэхээс үл хамааран төр хариуцан арилгана" гэж тус тус заасан байна.

Мөн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-т "...тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийг Засгийн газар гаргана" мөн хуулийн 8.3-д "Тухайн жилийн төсөвт урьдчилан төлөвлөж тусгах боломжгүй дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд энэ хуулийн 8.1-д заасан сангийн хөрөнгийг зарцуулна" гэж заажээ. Засгийн газрын нөөц сангаас гаргуулах шүүхийн шийдвэр бүхий иргэдэд төлөх төлбөрийг 2008 оноос хойш Хууль зүйн сайдын тухайн жилийн төсөвт тусгагдсан мөнгөн хөрөнгөөс шийдвэрлэх ажиллагааг зохион байгуулж, улмаар 2008-2014 оны байдлаар Засгийн газрын нөөц сангаас гаргуулах шүүхийн шийдвэртэй 137 иргэнд 1.5 тэрбум төгрөгийг олгосон байна

8 дугаар зүйл. Боолчлол албадан хөдөлмөрийг хориглох

Хөдөлмөрийн тухай хуульд "Адил хөдөлмөр эрхэлж байгаа эрэгтэй, эмэгтэй ажилтанд адил хэмжээний цалин хөлс тогтооно" гэж заасан боловч Тэгш шан хөлс олгох тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 100 дугаар конвенцийн "адил үнэлэмжтэй хөдөлмөр эрхэлж байгаа эрэгтэй, эмэгтэй ажилтанд тэгш шан хөлс олгох" гэсэн зарчим тусгагдаагүй байгаа. Энэ зарчмыг Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгасан.

Шинэчилсэн Эрүүгийн хуулийн төсөлд "Хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, илт хохиролтой болзол, нөхцөл тулгаж, эсхүл эдийн засаг, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдлыг далимдуулан эрхшээлдээ оруулж цалин хөлсгүй хөдөлмөр эрхлүүлсэн бол арван мянган тооцооны нэгжээс дөчин мянган тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ." гэж заасан.

"Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай" хуулинд "Ялтанд хийсэн хөдөлмөрийн тоо, чанарт тохирсон хөлс олгох, гэрээний үндсэн дээр ялтныг ажиллуулсан ажил олгогч ялтны хөдөлмөрийн хөлсийг хорих ангийн дансанд шилжүүлэх, төвлөрсөн цалин хөлсний 10 хүртэл хувийг ялтанд сар тутам авч хэрэглэх эрхтэй ба үлдсэнийг суллагдах үед өөрт нь олгох тухай заасан.

Уг хуулиар ялтныг эрх зүйн мэдээллээр хангах, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, ардын уламжлалт зан үйлд сургах болон бусад чиглэлээр хүмүүжлийн ажил зохион байгуулах, хүмүүжлийн ажилд хорих байгууллагын ажилтнуудаас гадна шашны, буяны болон бусад

байгууллага, иргэнийг оролцуулж болох зэрэг асуудлыг зохицуулсан. Иймд хорих байгууллагын зүгээс ялтанд хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслах, бололцоо нөхцлөөр хангахад анхаарч ажиллаж байгаа.

Тухайлбал: хорих ангийн дэргэд дархан, мужаан, зураг, сийлбэр, гар урлал, оёдлын мэргэжил эзэмшүүлэн, үйлдвэрлэл явуулах Сургалт- үйлдвэрлэлийн төв, оёдол, дархан, мужааны цех зэргийг тус тус байгуулан хоригдогсдыг нийгмийн амьдралд бэлтгэх, нийгэмшүүлэх, дахин хэрэг зөрчилд өртөхгүй үзэл санааг төлөвшүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа, ухааруулан сэнхрүүлэх арга хэмжээг мэргэжлийн сэтгэл зүйч, сурган хүмүүжүүлэгч, нийгмийн ажилтан нартай хамтран зохион байгуулж байна.

Түүнчлэн Насанд хүрээгүйчүүдийн хорих ангийн дэргэд гар урлал, хивс, мужаан, ноос боловсруулах чиглэлээр “Сургалтын төв”, насанд хүрээгүй хоригдлын засрал хүмүүжил, сэтгэл зүйд зөв төлөвшил бүрдүүлэх, нийгмийн амьдралд бэлтгэх зорилгоор “Сэтгэл зүйн кабинет”-ийг байгуулан ажиллаж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хорих ял эдэлж буй ялтныг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 120 дугаар зүйлд заасны дагуу Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн хөдөлмөрт татан оролцуулдаг ба Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2013 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/32 дугаар тушаалаар батлагдсан “Ялтны хөдөлмөрийн норм, хөлсний үнэлгээг тогтоох журам”, А/33 дугаар тушаалаар батлагдсан “Ялтан гэрээгээр ажиллуулахад мөрдөх заавар”, “Ялтныг аж ахуйн нэгж, байгууллагад хөлсөөр ажиллуулах гэрээ”-ний хүрээнд хөдөлмөрлүүлж байна. 2015 оны байдлаар 3298 ялтанг ажил хөдөлмөрт татан оролцуулж, 719.557.400 төгрөгийн цалин хөлс олгогдсон байна.

9 дүгээр зүйл. Халдашгүй, чөлөөтэй байх эрх

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 13 дугаар бүлэгт “Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг” гэсэн бүлэг шинээр орсон. Үүнд: “Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, хууль бусаар албадан хөдөлмөрлүүлэх, эд эрхтнийг нь авч мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж буй хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн, тээвэрлэсэн, орогнуулсан, дамжуулсан, хүлээн авсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэж заасан.

Мөн бүлэгт хүн хулгайлах, хүн барьцаалах, хүнийг хууль бусаар хорих, заналхийлэх зэрэг гэмт хэрэг, түүний хариуцлагууд орсон байна.

10 дугаар зүйл. Эрх чөлөөгөө хасуулсан хүн бүрийн өөртэй нь хүнлэг, нэр төрийг нь хүндэтгэх ёсоор хандах эрх

2002 онд шинэчлэгдсэн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 69.1 дүгээр зүйлд: Сэжигтнийг цагдан хорьж мөрдөх хугацаа 14 хүртэл хоног, яллагдагчийг хорьж мөрдөх хугацаа 2 сар хүртэл байдаг бөгөөд хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэргийн яллагдагчийг хэргийн төвөгтэй байдлыг харгалзан цаашид хорьж мөрдөх зайлшгүй шаардлагатай бол

шүүх уг хугацааг сунгах боловч хорьж мөрдөх нийт хугацаа 24 сараас хэтэрч болохгүй байхаар заасан ба харин Төр, нийгмийн зүтгэлтний амь биед халдах, Хорлон сүйтгэх, Хүнийг хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар санаатай алах, Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар зандалчлах, Төрлөөр устгах гэмт хэргийн яллагдагчийг энэ хуулийн 69.3 дугаар зүйлд зааснаас илүү хугацаагаар хорьж мөрдөх шаардлагатай бол шүүх 6 сар хүртэл хугацаагаар нэмж сунгаж болно гэж тус тус заасан.

Түүнчлэн үйлдсэн хэрэг нь хүнд, онц хүнд болон сэжигтэн оргон зугтахыг завдсан, эсхүл хүнд, онц хүнд гэмт хэрэгт сэрдэгдэх хангалттай баримт байгаа, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлж болох буюу эрүүгийн хэргийн бодит байдлыг тогтооход саад учруулж болох зэрэг онцгой тохиолдолд насанд хүрээгүй этгээдийг баривчлах буюу цагдан хорьж болно. Насанд хүрээгүй этгээдийг баривчилсан, цагдан хорьсон тухай түүний эцэг, эх, хууль ёсны бусад төлөөлөгч, өмгөөлөгчид нь 12 цагийн дотор мэдэгдэнэ. Мөн хуулийн 366.3 дугаар зүйлд “Баривчилсан ба цагдан хоригдсон насанд хүрээгүй этгээдийг насанд хүрсэн болон шийтгэгдсэн насанд хүрээгүй этгээдээс тусгайд нь байлгана” гэж заасан. Насанд хүрээгүй этгээдийг хорьж мөрдөх үндсэн хугацаа нэг сар байх бөгөөд хорьж мөрдөх хугацаа 18 сараас хэтэрч болохгүй байхаар хуульчилсан.

Мөн насанд хүрээгүй этгээд, эмэгтэйчүүд, онц аюултай гэмт хэрэгтэн, түүнчлэн гэмт хэрэгт удаа дараа шийтгүүлсэн этгээд, шүүхээр ял шийтгүүлсэн этгээдийг сэжигтэн, яллагдагчаас, дархлалын олдмол хам шинж, идэвхтэй хэлбэрийн уушигны сүрьеэ, бусад гоц халдварт өвчтэй болон тэдгээрийн нян тээгч этгээд, нэг хэргийн сэжигтэн, яллагдагч этгээдийг бусад сэжигтэн, яллагдагчаас тусгаарлан хорьдог.

Сэжигтэн, яллагдагчийн үйлдсэн хэргийн болон хувийн байдлыг харгалзан хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын саналын дагуу ганцаарчилсан өрөөнд хорьж болно. Харин ганцаарчлан хоригдсон этгээдийг бусад өрөөнүүдэд хоригдож байгаа этгээдтэй харилцах, ярилцах, ямар нэг эд зүйл дамжуулахыг хориглоно гэж заасны дагуу хэрэгт сэжиглэгдсэн эмэгтэйчүүд болон насанд хүрээгүй этгээдийг тусгаарлан хорих өрөөнд хорьж байна.

Эмэгтэйчүүд болон насанд хүрээгүй этгээдийн хорих өрөөг ахуй нөхцлийн хувьд бусад хоригдогчдын өрөөнөөс сайжруулан тохижуулж, тэдний эрүүл мэндэд тавих анхаарал, хяналт, хоолны хэмжээ, илчлэгийг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж хэвшээд байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 32 дугаар зүйлд заасны дагуу эмэгтэйчүүд болон насанд хүрээгүй этгээдийг насанд хүрсэн этгээдээс тусгаарлан хорьдог.

Хууль зүйн сайдын 2014 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/209 дүгээр тушаалаар батлагдсан “Хорих байрны дотоод журам” болон “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны үйл ажиллагааны стандарт”, “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”, бусад холбогдох хууль тогтоомжийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна.

11 дүгээр зүйл. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс эрх чөлөөг нь хасах

Өмнөх илтгэлд Монгол Улсын хууль тогтоомжид гэрээгээр хүлээсэн аль нэг үүргээ биелүүлээгүй гэсэн үндэслэлээр хүний эрх чөлөөг хязгаарлах тухай ямар нэгэн заалт байхгүй талаар дурдсан бөгөөд өнөөдөр мөн адил байгааг тэмдэглэж байна.

12 дугаар зүйл: Улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, явах, эх орондоо буцаж ирэх эрх

Монгол Улсын эрх зүйн салбар дахь хамтын ажиллагааны гол зорилгын нэг нь өөрийн улсын иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх болон ашиг сонирхлыг хилийн чанадад хангах, хамгаалах асуудал байдаг байна. Монгол Улсын гадаад харилцаа эрчимтэй хөгжиж эхэлсэн 1960-аад оноос эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх баримт бичгүүдийг бусад улс орнуудтай байгуулж өөрийн болон гадаад иргэдийн эрх ашгийг хамгаалж эхэлсэн. Нийт 19 улстай 26 гэрээг Иргэний хэргээр эрх зүйн туслалцаа үзүүлэх, Эрүүгийн хэргээр эрх зүйн туслалцаа үзүүлэх, Гэмт этгээд шилжүүлэх, Ялтан шилжүүлэх асуудлаар байгуулсан.

Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу Монгол Улсын иргэнийг харьяатаас хасах, эх орноосоо хөөх, өөр улсад шилжүүлэн өгөхийг хориглох бөгөөд Эрүүгийн хуулийн 15 дугаар зүйлд: 1) Монгол Улсын иргэнийг эрүүгийн хэрэгт мөрдүүлэх буюу эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр гадаад улсад шилжүүлж өгөхгүй; 2) Монгол Улсын хилийн гадна гэмт хэрэг үйлдсэн бөгөөд Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнийг эрүүгийн хариуцлага хүлээлгэх буюу ял эдлүүлэхээр Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу гадаад улсад шилжүүлж болно гэж заасан байна.

2015 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар Монгол 1810083 иргэн гадаад улсад зорчсон/гарсан/ байна. Мөн гадаадын 442017 иргэн Монгол Улсад зорчсон/орсон/ байна.

13 дугаар зүйл: Гадаадын иргэдийг албадан гаргах

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийг 2010 оны 7 дугаар сарын 08-ны өдөр баталж, 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдөр 2013 онд нэмэлт өөрчлөлт орсон. Энэхүү нэмэлт өөрчлөлтөөр Гадаадын иргэн харьяатын асуудал эрхлэх газар нь Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар нэртэйгээр өөрчлөгдөж, үйл ажиллагаа нь 2014 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Хилийн боомтын тухай хуулийн дагуу өргөжсөн.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн **37 дугаар зүйлд** гадаадын иргэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй байвал дараах үндэслэлээр Монгол Улсаас албадан гаргана: 1.Монгол Улсын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр бус буюу хуурамч баримт бичгээр нэвтэрсэн нь нотлогдсон;

2.оршин суух зөвшөөрлийн хугацаа нь дууссан боловч Монгол Улсаас гарч явахаас зайлсхийсэн;

3.түр ирэгч нь виз, бүртгэлийн журмыг хоёр буюу түүнээс дээш удаа зөрчиж энэ хуульд заасан хариуцлага хүлээсэн;

4.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хориглосон үйл ажиллагаа явуулсан;

5.Сэтгэцийн өвчтэй болохыг нь эрүүл мэндийн байгууллага тогтоосон; /Энэ заалтад 2012 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

6.хуурамч баримт бичиг ашиглаж виз, оршин суух зөвшөөрөл авсан, эсхүл виз, оршин суух зөвшөөрлийг засварласан буюу хуурамчаар үйлдсэн;

7.эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хөдөлмөр эрхэлсэн, ирсэн зорилгоосоо өөр үйл ажиллагаа явуулсан;

8.энэ хуулийн 35.1-д заасны дагуу Монгол Улсаас сайн дураараа гарах сануулгыг биелүүлээгүй;

9.нийгмийн хэв журмыг хоёр буюу түүнээс дээш удаа зөрчиж захиргааны арга хэмжээ авагдсан гадаадын иргэний талаар цагдаагийн байгууллагаас үндэслэл бүхий санал ирүүлсэн;

10.Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын эсрэг үйл ажиллагаа явуулж болзошгүй этгээд гэж холбогдох байгууллагаас үзсэн;

11.*шүүхээр ял шийтгүүлсэн гадаадын иргэн ялаа эдэлж дууссан буюу ялаас чөлөөлөгдсөн, эсхүл тухайн гадаадын иргэнийг Монгол Улсын олон улсын гэрээний дагуу харьяалах улсад нь шилжүүлэхээр болсон;*

12.түр ирэгч визийн хугацааг хэтрүүлсэн.

1. Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах тухай шийдвэрийг гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга гаргана.

2. Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Монгол Улсаас албадан гаргаж байгаа гадаадын иргэний фото зураг, гарын хурууны хээг авч мэдээллийн сан бүрдүүлнэ. Албадан гаргах тухай шийдвэрийг иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хил хамгаалах болон цагдаагийн байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

3. Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь албадан гаргаж байгаа гадаадын иргэний паспорт, баримт бичигт Монгол Улсад орохыг хориглосон хугацааг заасан тэмдэглэл хийнэ. Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах зардлыг гадаадын иргэнээс өөрөөс нь, эсхүл уригчаас гаргуулах ба хэрэв төлбөрийн чадваргүй бол уг зардлыг Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гаргана.

4. *Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах нь улс хооронд ялтан шилжүүлэх асуудалд үл хамаарна.* Албадан гаргаж байгаа гадаадын иргэнийг харьяалах улсад нь шилжүүлнэ.

5. Хэрэв шууд шилжүүлэх боломжгүй бол урьд нь оршин сууж байсан буюу төрсөн улсад нь; Монгол Улсад нэвтрэн орж ирэхдээ хамгийн сүүлд дамжин орж ирсэн улсад нь; визийг нь авсан улсын аль нэгэнд шилжүүлж болно.

6. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 46 дугаар бүлэгт гадаад улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн буюу шийтгэгдсэн гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнийг шилжүүлэн өгөх, 47 дугаар бүлэгт Монгол Улсын шүүхэр хорих ял шийтгүүлсэн этгээдийг харьяат улсад нь шилжүүлэн өгөх талаар зохицуулсан бөгөөд эдгээр асуудлыг олон улсын гэрээ, хэлэлцээрт заасны дагуу шийдвэрлэнэ гэсэн байна.

7. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 46, 47 дугаар зүйлүүдэд шилжүүлэн өгөхөөс татгалзах үндэслэлүүдийг тусгасан боловч “эрүүдэн шүүх аюул тулгарна” гэж үзэх хангалттай үндэслэл байх тохиолдлыг тусгайлан заагаагүй боловч Монгол Улсын нэгдэн орсон гэрээ хэлэлцээр, байгуулсан хоёр талт гэрээ, хэлэлцээрүүдэд татгалзах үндэслэл болох тохиолдолуудыг тусгасан байдаг.

8. Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээний зүйлд эрх зүйн хамгаалалтын асуудал багтах бөгөөд мөн зарим хөнгөлөлтийг агуулж болдог. 1954 оны иргэний процессын асуудлын тухай Гаагийн конвенцийн 24 дүгээр зүйлийн дагуу харилцан хэлэлцэгч улсууд

иргэний бүртгэлийн талаарх мэдээллийг үнэ төлбөргүй авах эрхтэй. Хэлэлцэн тохирогч улсууд үндэсний дэглэмийг харилцан тэгш олгох зарчим дээр үндэслэн тэгш олгоно.

2015 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар Монгол Улсад нийт 121 улсын 27814 гадаадын иргэн оршин сууж байгаагаас цагаач насанд хүрсэн иргэд нийт 1574, насанд хүрээгүй 354 байна. Харьяалалгүй иргэд нийт 36, үүнээс харьяалалгүй цагаач 18, насанд хүрээгүй 1 хүн тус улсад оршин сууж байна.

14 дүгээр зүйл. Шүүхийн өмнө эрх тэгш байх

Шүүхийн тухай багц хуулиуд 2013 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн. *Зохион байгуулалтын ганц хуулиас процесжуулан зохицуулсан багц хуульд шилжсэн тухай* Монгол Улсын Үндсэн хуульд төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл гэж хуваарилснаар шүүх эрх мэдлийн бие даасан байх эрх зүйн үндэсийг тогтоосон. Энэхүү үзэл баримтлалыг хэрэгжүүлэх зорилгоор 1993 онд Шүүхийн тухай хуулийг баталснаас хойш 20 жилийн дараа 2013 оны 4 дүгээр сарын 15-наас Шүүхийн тухай багц хууль хэрэгжиж эхэлсэн. Эдгээр 5 хууль нь шүүх эрх мэдэлд хамааралтай бүх харилцааг цогцоор нь зохицуулснаараа ач холбогдолтой. Шүүхийн тухай багц хууль батлагдснаас хойш "Шүүх байгуулах тухай хууль" /шинэчилсэн найруулга/ 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдөр батлагдан 2015 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Шүүн таслах болон шүүхийн захиргааг салгасан нь шүүх бусад эрх мэдлээс хараат бус бие даан ажиллах нөхцөл бүрдсэн. Шүүхийн захиргааны тухай хуулиар Шүүхийн ерөнхий зөвлөлд Үндсэн хуулиар заасан үзэл баримтлал, эрх зүйн үндсийн хүрээнд бүрэн эрхээ бодит утгаар нь хэрэгжүүлэх бүх талын бодит боломжийг анх удаа бүрдүүлж өгсөн. Шүүх эрх мэдлийг засгийн бие даасан салаа болгосон ба эрх мэдлүүд хоорондын хяналт, тэнцвэрт байдлыг хангахын тулд шүүхийн тогтолцоог үндсэн, дагнасан болон төрөлжсөн шүүхээс бүрдүүлэхийн зэрэгцээ шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах зорилго бүхий "Шүүхийн ерөнхий зөвлөл" ажиллах эрх зүйн үндсийг хуульчлан тогтоосонд оршино. Уг хууль батлагдан гарснаар Шүүхийн ерөнхий зөвлөл, түүний ажлын алба, бүх шатны шүүхийн Тамгын газар шүүгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад чиглэгдсэн захиргааны бүхий л үйл ажиллагааг бие дааж явуулдаг болсон. Шүүгч зөвхөн шүүн таслах ажиллагаа явуулдаг болсноор шүүх бусад эрх мэдлээс хараат бусаар үйл ажиллагаа явуулах үндэс бүрдсэн.

Шүүхийн үйл ажиллагааг олон нийтэд ил тод, нээлттэй, хүртээмжтэй байлгах хуулийг нэг мөр, зөв хэрэглэх зорилгоор хувь хүн, байгууллага, төрийн нууцтай холбоотойгоос бусад шүүхийн шийдвэр, магадлал, тогтоол байршуулсан шүүхийн шийдвэрийн цахим сан /www.shuukh.mn, shuukh.app/-г нээлттэй ажиллуулж байгаа билээ. Одоогийн байдлаар цахим санд 133349 хэргийн 180868 шийдвэр байршуулаад байна.

Нийт шүүхийн 105 шүүх хуралдааны танхимд дуу болон дүрс бичиж, архивлах тоног төхөөрөмж суурилуулснаар сонирхсон этгээд нээлттэй шүүх хуралдааныг шүүхийн байранд шууд үзэх, хэргийн оролцогчид бичлэгийг хуулж авах, прокурор, цагдаагийн байгууллага сургалтанд ашиглах, давж заалдах шатны шүүх хуулбарлан авах, шүүхийн ёс зүйн хороо тухайн шүүгчид холбогдох шүүх хуралдааны бичлэгийг хуулбарлан авах зэрэг байдлаар ашиглах боломжтой.

Мөн орон нутгийн нийт шүүхүүдэд видео хурлын төхөөрөмж суурилуулснаар Шүүхийн ерөнхий зөвлөлөөс бүх төрлийн сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг онлайн хэлбэрээр явуулж байгаа юм. Үүнээс гадна шүүхүүд хоорондоо холбогдож мэдээ, мэдээлэл солилцох, шүүх хуралдаанд алсын зайнаас нэхэмжлэгч, хариуцагч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, гэрч, шинжээчийг оролцуулж байна. 2015 онд нийт 127 удаа энэхүү системийг ашиглажээ. Тухайлбал, орон нутгийн шүүх хуралдаанд Улаанбаатар хотоос 26 удаа, орон нутгийн шүүх хуралдаанд бусад орон нутгаас 78 удаа, шүүхийн ерөнхий зөвлөлөөс явуулсан сургалт семинар 23 удаа тус тус ашиглаад байна.

Шүүх бүхэлдээ дагнасан нь мэргэшсэн шүүх, шүүгчээр иргэд хэрэг маргаанаа шийдвэрлүүлэх эрхтэй болсон. 2013 оны Шүүхийн тухай багц хуулийн бүрдэл хэсэг болох Шүүх байгуулах тухай хуулиар нийслэл болон зарим орон нутгийн анхан болон давж заалдах шатны шүүхийг эрүү, иргэний хэргээр дагнан бие даасан байдлаар байгуулж улсын хэмжээнд нийт 75 шүүх шүүн таслах үйл ажиллагааг дагнан хэрэгжүүлж эхэлсэн. Харин 2015 оны Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгаар орон нутаг дахь сум дундын 6 шүүхээс бусад бүх анхан шатны шүүхийг эрүү, иргэний хэргээр дагнан байгуулж, улсын хэмжээнд нийт 99 шүүх шүүн таслах ажиллагааг явуулж, иргэд хэрэг маргаанаа дагнасан мэргэшсэн шүүх, шүүгчээр шийдвэрлүүлэх бүрэн боломж нээгдсэн.

Төсвийн бие даасан байдал, улсын төсөвд эзлэх хувь хэмжээ, төсвийн хамгаалалт, шүүгчдийн цалин, бусад хамгаалалт

Шүүхийн шинэчлэлийн хүрээнд Шүүх үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана гэсэн үндсэн хуулийн заалтыг хэрэгжүүлэх талаар төрөөс онцгой анхаарч шүүхийн тухай багц хуульд тусгасан.

Шүүхийн үйл ажиллагааны төсвийг өмнөх жилийнхээс бууруулахыг хориглоно, Шүүхийн ерөнхий зөвлөл шүүхийн төсвийг төлөвлөн Улсын Их Хуралд шууд өргөн мэдүүлнэ, Шүүхийн бие даасан байдлын зарчмыг алдагдуулсан, шүүгчийн эрх зүй, эдийн засаг, нийгмийн хамгаалалт зэрэг хараат бус, халдашгүй байдлын баталгааг дордуулсан хууль тогтоомж, захиргааны акт гаргахыг хориглоно, Шүүгчийн амь нас, эрүүл мэндийн даатгалын хураамжийг улсын төсвөөс хариуцна, Шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээ нь эдийн засгийн хувьд бусдаас хараат бус ажиллах, амьдрахад хүрэлцээтэй, баталгаатай байх боломжийг хангасан байна гэсэн тодорхой хуулийн заалтууд бий болж шүүх засаглалын эдийн засгийн дархлаа бүрдэж хараат бусаар үйл ажиллагаа явуулах нөхцөл хуулиар баталгаажсан.

Шүүхийн 2015 оны төсөв 58.8 тэрбум болж 2012 оны төсөв 20.9 тэрбумаас 2.8 дахин, улсын нэгдсэн төсөвт эзлэх хувь 0.33% байснаас 0.75% болж 2.26 дахин өссөн байна. Шүүхийн төсвийг 2013 оноос нэмэгдүүлснээр шүүхийн байрыг засах, тоног төхөөрөмжийг сайжруулах, тавилгыг шинэчлэх, шүүгчийн амь нас, эрүүл мэндийг даатгах, шүүхийг иргэдэд нээлттэй болгох, шүүгчийн орон тоог өсгөх, шүүгчийн албан тушаалын цалинг нэмэгдүүлэх томоохон ажлуудыг үе шаттайгаар амжилттай зохион байгуулан ажиллаж байна.

Шүүхийн сүүлийн 4 жилийн төсөв, нээгдсэн төсвийн нийт зарлагад эзлэх хувь



Хэдий тийм ч бүх шатны шүүхэд 2014, 2015 онд хөрөнгө оруулалтын төсөв батлагдаагүй нь 2013 оноос хойш нэмэгдсэн шүүгч, шүүхийн захиргааны ажилчид байрандаа багтахгүй, ашиглалтын хугацаа нь дуусч мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гарсан, гадаад орны байгууллагын байрыг түрээслэн хэрэг шүүн таслах үйл ажиллагаа явуулахад хүргэж байгаа тул цаашид шүүх өөрийн байртай байна, шүүхийн байранд өөр үйл ажиллагаа явуулахыг хориглосон хуулийн заалтыг хэрэгжүүлэх, шүүх засаглалын хараат бус байдлыг бататгах, эдийн засгын баталгааг сайжруулах, хууль эрх зүйн орчинг улам боловсронгуй болгох, шүүхийн зориулалтын, стандарт хангасан байртай болох зайлшгүй шаардлага тулгараад байна.

Эдийн засгийн хараат бус байдал- цалин бусад хамгаалалт, нөлөөллийн мэдүүлэг, бусад зохицуулалт Шүүгч, шүүхийн ажилтны нийгмийн хамгааллыг сайжруулах ажлын хүрээнд "Шүүгч, шүүхийн захиргааны ажилтны нийгмийн хамгаалал"-ын хөтөлбөрийг баталж, 2014-2020 он хүртэл хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт "Шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээ нь шүүгч эдийн засгийн хувьд хараат бусаар ажиллаж, амьдрахад хүрэлцээтэй, баталгаатай байна" гэж заажээ.

Хуулийн энэхүү заалтыг хэрэгжүүлж, батлагдсан төсвийн хүрээнд шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээг Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2013 оны 45 дугаар тогтоолоор тогтоосон нь хуулийг хэрэгжүүлж, шүүгч эдийн засгийн хувьд хараат бус байх баталгаа хангагдах нөхцлийг бүрдүүлсэн.

Шүүгчийн цалин хөлс /Дундажаар/	Шүүгчийн цалин хөлс /Дундажаар/		
	Хяналтын шатны шүүхийн шүүгч	Давж заалдах шатны шүүхийн шүүгч	Анхан шатны шүүхийн шүүгч
■ Өмнө авч байсан /УИХ 2011 оны 36, 54-р тогтоол, нэмэгдлийн хамт/	2,005,826	1,516,328	1,427,709
■ Одоо авч байгаа /ШЕЗ-ийн 2013 оны 45-р тогтоол/	3,204,000	2,919,811	2,716,814

Шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээг батлагдсан төсвийн хүрээнд хуулийг хэрэгжүүлж олгосноор багц хууль хэрэгжиж эхэлснээс хойш шүүгчийн эрх ашгийг хамгаалах, цаашлаад хүний эрх, эрх чөлөө, шударга ёсны баталгааг хангах ажилд оруулсан томоохон хэмжээний хөрөнгө оруулалт боллоо.

Шүүгчид нөлөөлөх оролдлого гарахаас урьдчлан сэргийлж шүүгч нөлөөллийн мэдүүлэг бөглөдөг болсон. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын гол баталгаа нь шүүгч гагцхүү хуульд захирагдан, хэрэг маргааныг хэнээс ч хараат бусаар шийдвэрлэх явдал юм. Шүүгч, шүүх бүрэлдэхүүнд хянан шийдвэрлэж буй хэрэг маргаантай нь холбогдуулан аливаа этгээдээс нөлөөлөх оролдлого хийвэл шүүгч нөлөөллийн мэдүүлэг хөтөлж, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан хараат бус байдал хамгаалагддаг арга хэрэгслийн нэг билээ.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсэгт заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлд шүүгчдээс нийт 12 нөлөөллийн мэдүүлгийг хөтлөн ирүүлжээ. "Нөлөөллийн мэдүүлэг шийдвэрлэх журам"-ыг ШЕЗ-өөс 2015 оны 05 дугаар сарын 08-ны өдөр баталснаас хойш 3 нөлөөллийн мэдүүлэг ирснийг холбогдох байгууллагад хянан шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн байна.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан шүүгчийн нийгмийн баталгааг хангах зорилгоор "Бодь даатгал" ХХК-тай гэрээ байгуулснаар анхан болон давж заалдах шатны нийт шүүхийн шүүгчийн амь нас, эрүүл мэндийг даатгаж, эрсдэлээс хамгаалах нөхцөл бололцоог бүрдүүллээ.

Мөн Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6, 24.7 дахь хэсэгт заасан шүүгчийн эрх хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж зөрчигдөхөөс сэргийлэх, хууль тогтоомжийн зөрчилдөөнт байдлыг арилгах, уялдаа холбоог сайжруулах зорилгоор Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийг боловсруулан, хууль санаачлагчид өргөн барилаа.

Иргэдийн хооронд энх тайванч уур амьсгал бүрдүүлэх, шүүхийн ачааллыг бууруулах, маргааныг шуурхай шийдвэрлэхэд нь иргэдэд тусалж буй хэлбэр болсон. Шүүхийн тухай багц хуулийн нэг хэсэг болох Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш буюу 2014 оны 02 дугаар сарын 04-ний өдрөөс хойш Японы ЖАЙКА төсөл, Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөл, Шүүхийн ерөнхий зөвлөл хамтран нийт 20 удаагийн сургалтаар 677 эвлэрүүлэн зуучлагч нарыг бэлтгэсэн бөгөөд тэдгээрийг 2 удаагийн давтан сургалтад хамруулсан байна. Мөн тус байгууллагууд хамтран 12 аймгийн эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаанд мониторинг, эвлэрүүлэн зуучлалын тухай хууль сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулж, Япон улсад 3 удаагийн сургалтаар нийт 66 хүнийг эвлэрүүлэн зуучлалын чиглэлээр сургалтад хамруулаад байна.

2014 оны шүүхийн эвлэрүүлэн зуучлах ажиллагааны бүтэн жилийн нэгдсэн дүн мэдээгээр шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид нийт 6427 нэмэмжлэл болон өргөдөл хүлээн авсанаас 5122 өргөдлийг шийдвэрлэсэн байна. 5122 өргөдөл шийдвэрлэлтээс 2847 нь эвлэрэл амжилттай болсон байна.

2015 оны хагас жилийн дүн мэдээгээр 7511 өргөдөл хүлээн авсанаас 5748 өргөдлийг шийдвэрлэж, үүнээс 3842 буюу 66.8 хувьд эвлэрэл амжилттай болсон байна.

Монгол Улсын шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагааны 2015 оны эхний хагас жилийн дүнг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал: Шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид гаргасан өргөдөл 3.2 дахин, шийдвэрлэсэн байдал 3.5 дахин, шүүхээс иргэний хэрэг үүсгэсний дараа шилжүүлэн ирсэн иргэний хэрэг 2.1 дахин тус тус өссөн байна.

Үүнээс харахад жил ирэх бүр иргэдийн шүүх дэх эвлэрүүлэн зуучлалаар хэрэг маргаанаа шийдвэрлүүлэх байдал болон эвлэрүүлэн зуучлалын амжилттай болсон нөхцөл тус бүр нэмэгдэж байгаа нь шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаа үр дүнтэй байгаагийн илрэл төдийгүй, шүүх, шүүгчийн ачаалал тодорхой хэмжээгээр хөнгөлөгдөж байгаа ач холбогдолтой үйл явц юм.

Шүүгчдийн орон тоо хангалттай нэмэгдсэний үр дүн, ач холбогдол, сонгон шалгаруулалт, хуульчдын өрсөлдөөн, сонгон шалгаруулах шинэ арга хэлбэр, 100 шүүгч шинээр нэмэгдсэний үр дүн, ач холбогдол

Монгол Улсын хувьд шүүхийн шинэтгэл хэрэгжиж шүүгчийн сонгон шалгаруулалт шинэ шатанд гарсан юм. Шүүгчийн сонгон шалгаруулалтыг ил тод, шударга, нээлттэй, хөндлөнгийн нөлөөллөөс ангид, цаг хугацаа, зардал хэмнэн явуулах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөл, АНУ-ын Олон улсын хамтын ажиллагааг дэмжих хөтөлбөрийн санхүүжилтээр Азийн сангийн хэрэгжүүлж буй "Засаглал, ил тод байдлыг дэмжих" төслөөс санхүүжилт хийлгэн хамтран ажиллаж "ШҮҮГЧИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН СИСТЕМ"-ийг нэвтрүүллээ. Ингэснээр шүүгчийн сонгон шалгаруулалтыг цахимаар явуулж эхлэхийн зэрэгцээ хүн хүч, цаг хугацаа, зардал хэмнэж, нэр дэвшигчийг хөндлөнгийн нөлөөллөөс ангид, шударгаар үнэлж, дүгнэх нөхцөл бүрдсэн цогц шинэлэг шийдэл байлаа. Мөн шүүгчийн сонгон шалгаруулалтын журам, Шүүхийн мэргэшлийн хорооны үйл ажиллагааны журам, Шүүхийн мэргэшлийн хорооны гишүүдийн ашиг сонирхлын эсрэг журам зэрэг хууль эрх зүйн шинэ тогтолцоо бүрдсэнээр хараат бусаар ажиллах шүүхийн мэргэшлийн хороо, шүүгчид нэр дэвшигчийг олон улсын жишигт нийцсэн арга, хэрэгслээр зөв шудрага шалгаруулах нөхцөл байдал бүрдсэн. Тухайлбал: шүүгчид нэр дэвшигчийн зан төлвийн үнэлгээг сонгон шалгаруулалтын аргад нэвтрүүлсэн үйл явдал юм. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4.1.5-д шүүгчид тавих шаардлагад мэргэжлийн ёс зүйгээ ухамсарласан, шудрага ёсыг эрхэмлэдэгхүний эрхийг дээдлэх, бусдын нөлөөнд автахгүй, бие даасан шийдвэр гаргах чадвартай; хэмээн заасан байна. Үүний дагуу Шүүгчийн сонгон шалгаруулах журмын 3.1.2,3-д нэр дэвшигчийн "мэргэжлийн ёс зүй", "шүүгчээр ажиллах зан төлөв"-г үнэлж, дүгнэх шалгуурыг бий болгосон.

"Шүүгчид нэр дэвшигчийн мэргэжлийн ёс зүйг дүгнэх үнэлгээний хуудас"-ыг нэр дэвшигчийг тодорхойлж чадахуйц этгээдүүдээс тохиолдлын журмаар авахаар шүүгчийн сонгон шалгаруулалтын журамд тусгасан. Энэ нь шүүгчид нэр дэвшигчийн ёс зүй, зан төлвийг тогтоох шинэлэг арга болсон. Нэр дэвшигчийн өнгөрснийг судлах, мэргэжлийн хувьд хэр ёс зүйтэй хүн байсныг тогтоох нь ёс зүйтэй шүүгчийг тодруулах ач холбогдолтой.

Дээрх шинэчлэлийн дагуу шүүхийн шинэтгэлийн хүрээнд 100 шинэ шүүгчийг шүүхийн "гал тогоо"-нд оруулж, шүүхийн хүний нөөцийг шинэ шүүгчээр сэлбэлээ. Өөрөөр хэлбэл Монголын нийт шүүгчдийн 13 хувийг шинэчилсэн байна. Шинээр томилогдсон шүүгчдийн 52,3 хувь нь шүүхийн гаднаас буюу өмгөөлөгч, прокурор, хуулийн зөвлөх зэрэг мэргэжлээрээ ажиллаж байсан дадлага туршлагатай хуульчид шүүгч болсноор онцлог болсон. Мөн эдгээр шүүгчийн 25 нь буюу 39,7 хувь магистр зэрэгтэй байгаагаас үзэхэд шинээр томилогдсон шүүгчдийн боловсролын түвшин ахисан болохыг харуулж байгаа үзүүлэлт боллоо. Шүүхийн шинэтгэлийн хүрээнд шүүгч нарын тодорхой хэмжээгээр шинэчилсэн нь анхан болон давж заалдах хяналтын шатны нийт шүүгчдийн дундаж нас 43,4 байгаа шүүгчдийн дундаж насны тоон үзүүлэлтээс харагдаж байна. Тухайн орон нутагт олон жил шүүгчээр ажилласан, субъектив нөлөөлөлд өртөх магадлалтай нас тогтсон шүүгчдээс илүү шинээр тухайн орон нутагт томилогдсон залуу, мэдлэг

боловсролтой хуульдаас шүүгчдийг шилж сонгосон нь шүүх танил талаараа хэрэг шийдвэрлэдэг гэсэн олон нийтийн хардалтыг багасгах ач холбогдолтой.

Шүүхийн боловсролын тогтолцоог боловсронгуй болгох, үргэлжилсэн сургалтыг хөгжүүлэх бодлого, стратегийг шинэчлэн тодорхойлж "Шүүхийн сургалтын хөтөлбөр"-ийг боловсруулан хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургагч багш нарын нөөцийг бүрдүүлэх болон сэдэвчилсэн сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулсан нь сургалтын агуулгыг шүүхийн шинэтгэлийн үзэл баримтлал, олон улсын нийтлэг чиг хандлагад нийцүүлэн өөрчлөх эхлэл боллоо.

Тахарын хамгаалалт: шүүх хуралдааны дэг, гэрч хохирогчийг хамгаалах, шүүхэд дуудан ирүүлэх

Тахарын албаны тухай Монгол Улсын хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.3, 6.1.4, 6.1.6 дахь заалтууд, Хууль зүйн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2014 оны А/96, 90 дугаар хамтран баталсан "Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах журам"-ын заалтуудыг мөрдлөг болгон 2015 оны эхний хагас жилийн байдлаар шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг ханган ажиллах ажлын хүрээнд улсын хэмжээнд 43 шүүхийн 42 шүүхийн байранд өдөр тутам 24 цагаар тахарын албаны харуул хуяг, өдрийн 8 цагаар журам сахиулах үүрэг гүйцэтгэж байна.

Үүрэг гүйцэтгэх хугацаанд эрүүгийн хэргийн 6947, иргэний хэргийн 16787, захиргааны хэргийн 3076, үүнээс онлайн сүлжээний хурал 68 нийт 27453 шүүх хурал хуралдсанаас 14737 шүүх хуралдааны журмыг сахиулан шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэн, шүүхийн байранд 191447 иргэнийг бичиг баримтыг шалгаж нэвтрүүлж ажилласан.

Шүүх хуралдааны явцад 91572 оролцогчдын аюулгүй байдлыг хангаж, шүүхийн шатанд шүүгдэгчээс батлан даалтанд өгөх таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан 1219, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан 812, шүүхээс хорих ялаар шийтгэгдсэн 1466, хорихоос өөр төрлийн ял шийтгэл оногдуулсан 1816, яллагдагч, шүүгчдэгчид холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосон 406 удаагийн шүүх хуралдааны журам сахиулсан.

Шүүхийн түр саатуулах байранд яллагдагч, шүүгдэгч нарын эрх ашгийг хангаж өмгөөлөгчтэй 706 удаа, тэдгээрийн хамаарал бүхий этгээдүүдтэй 1681 удаагийн түр уулзалтыг зохих хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.

Шүүхийн байранд болон бусад газар шүүх хурал болохтой холбогдуулж олон оролцогчтой, шүүх хуралдааны хэвийн явагдах нөхцөлийг хангах зорилгоор хүч нэмэгдүүлсэн хамгаалалт 29 удаа явуулсан байгуулсан.

Гэрч, хохирогчийн хамгаалах арга хэмжээний хүрээнд иргэнээс ирүүлсэн 22, өмгөөлөгчөөс гаргасан 2, шүүгчийн захирамжийн дагуу 2, Шүүхийн тамгын газраас Шүүгчийн хамгаалалтанд авах тухай 3 албан бичиг, Цагдаагийн газраас хохирогчийг хамгаалуулах тухай 4, Төв аймгийн цагдаагийн газраас гэрчийг хамгаалуулах тухай 1, ТББайгууллагаас ирүүлсэн 2 нийт 36 өргөдөл, хүсэлт хүлээн авч, урьдчилан сануулах 11, биечлэн хамгаалалт 3, аюулгүй газар түр байрлуулах арга хэмжээ 2, техник тоног төхөөрөмжөөр хангах арга хэмжээ 1 удаа тус тус зохион байгуулж, шүүгч 1, хохирогч 13, гэрч 5, хохирогчийн хамаарал бүхий этгээд 19 нийт 38 иргэний аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээ авсан байна.

Сэжигтэн, яллагдагчийг хуяглан хүргэх арга хэмжээний хүрээнд цагдан хорих байрнаас шүүх хуралдаанд оруулахаар 1882, шүүхээс цагдан хорих байранд 3091, цагдан хорих байрнаас орон нутгийн жирийн дэглэмтэй хорих байранд 289, баривчлах ял эдлүүлэх ангид 55, дамжин өнгөрүүлэх ангид 199, сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний

төвд 9, эмэгтэйчүүдийн хорих ангид 12 нийт эрэгтэй 4120, эмэгтэй 204, насанд хүрээгүй 48, хөгжлийн бэрхшээлтэй 15 сэжигтэн, яллагдагч нарыг хуяглан хүргэх ажиллагаа зохион байгуулсан байна.

Шүүхэд гэрч, хохирогч, яллагдагч, бусад оролцогчийг албадан ирүүлэх шүүгчийн 567 захирамжийг хүлээн авч 1093 удаагийн ажиллагаа гүйцэтгэж яллагдагч 18, хариуцагч 504, хохирогч 6, нэхэмжлэгч 1, шинжээч 4, гэрч 18-ыг албадан ирүүлэх арга хэмжээ авсан.

Шүүхээс иргэний хэргийн хариуцагчийг эрэн сурвалжлах 2869 шийдвэр хүлээн авч 1320 иргэний хариуцагчийн хаяг, байршлыг тогтоон шүүхэд хариу хүргүүлж, 1516 иргэний хэргийн хариуцагчийг эрэн сурвалжлах ажиллагаа хийгдэж байна.

Шүүн таслах ажиллагаанаас оргон зайлсан 2, прокурорын хяналтаас оргон зайлсан 4 яллагдагчийг олж хүлээлгэн өгсөн байна.

2007 онд шүүхэд итгэдэггүй гэх хувь 77 хувь байсан бол одоо шүүхээр үйлчлүүлсэн хүмүүсийн 81 хувь, шүүхээр үйлчлүүлээгүй иргэдийн 60 хувь шүүхэд итгэж байна гэсэн ахиц гарлаа. Шүүхийн шинэтгэлийн хөтөлбөр батлагдсанаас хойш шүүхийн шинэтгэлийн үйл явц болон шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх үйл явц огтхон ч тасалдан саатаагүй бөгөөд энэ хоёр үйл явцын үр дүнг илэрхийлэх, үнэлэх бараг цорын ганц шалгуур үзүүлэлт бол шүүх засаглалд итгэх олон түмний итгэл юм.

Шүүхийн шинтгэлийн үйл явц эхлэхээс өмнө 2008 онд нээлттэй нийгэм форумаас АНУ-ын профессор Брент Уайлтаар хөндлөнгийн судалгаа хийлгэхэд шүүрэд итгэх итгэл 23.0 хувь, 2010 онд Сант марал судалгааны төвийн хийсэн судалгаагаар энэ үзүүлэлт 15.0 хувьтай болж буурч байсан байна.

Шүүхийн шинэтгэл эрчимтэй эхэлсэнээс хойш буюу шүүхийн багц хууль хэрэгжиж эхэлсэнээс хойш 1,5 жилийн хугацаанд иргэд олон нийт шүүхэд итгэх итгэл хэрхэн өөрчлөгдсөнийг тодорхойлох зорилгоор олон нийтийн санал бодлын судалгаа хийсэн болно.

Шүүхэд итгэх иргэдийн итгэл” судалгааг зохион байгуулсан ба судалгаанд Монгол Улсын 21 аймаг, 9 дүүргийн хөдөлмөрийн насны хүн амын төлөөлөл хамрагдсан. Судалгаа санамсаргүй түүврийн аргаар хийсэн ба экспертийн ярилцлагыг удирдах түвшний хүмүүсийн дунд зохион байгуулж, шүүхийн ажилтнууд, шүүхээр үйлчлүүлж байсан болон шүүхээр үйлчлүүлж байгаагүй нийт 3290 хүн хамрагдсанаас шүүхээр үйлчлүүлээгүй иргэд 2522, шүүхээр үйлчлүүлсэн иргэд 645 байсан байна. Энэ судалгаагаар шүүхээр үйлчлүүлсэн болон шүүхээр үйлчлүүлж байгаагүй иргэдийн 60.6 хувь нь өнөөдөр шүүх хэрэг маргааныг хуульд нийцүүлэн шудрагаар шийдвэрлэж байна гэдэгт итгэдэг гэж хариулсан ба энэ үзүүлэлт шүүхээр үйлчлүүлсэн иргэдийн хувьд бүүр өндөр 81.4 хувь нь шүүхийн үйл ажиллагаа шудрага болно гэдэгт итгэж байна. Харин шүүхээр үйлчлүүлээгүй иргэд шүүх хэрэг маргааныг шудрага ар шийдвэрлэдэг гэдэгт итгэдэггүй /39.8/, тэрчлэн хариулж мэдэхгүй байгаа 21.5 хувийн хамарч байгаа хүмүүсийн эзлэх хувь шүүхээр үйлчлүүлсэн иргэдийнхээс өндөр байна.

Судалгаанд оролцогчид шүүхийн шинэтгэлийн үйл явцыг дэмжиж байгаа эсэх

	Шүүхийн шинэтгэлийн дэмжлэг			
	Дэмжиж байгаа	Дэмжихгүй байгаа	Мэдэхгүй	Бүгд
Шүүхийн ажилтанууд	93.8	6.2	0.0	100.0

Шүүхээр үйлчлүүлсэн иргэд	61.5	10.6	27.9	100.0
Шүүхээр үйлчлүүлээгүй иргэд	46.1	8.1	45.8	100.0
Бүгд	67.1	8.3	24.6	100.0

Шинэтгэлийн хүрээнд хэрэгжүүлсэн олон алхам, арга хэмжээнүүдээс иргэд олон нийт хамгийн өндөр үнэлж байгаа нь шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод болсон явдал юм. Энэ бол шүүхэд итгэх иргэдийн итгэлийг дээшлүүлсэн, шүүхийн шинэтгэлийг дэмжих иргэдийн дэмжлэгийг нэмэгдүүлсэн чухал арга хэмжээ, чухал алхам болжээ.

15 дугаар зүйл. Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхгүй байх

2002 онд батлагдсан Эрүүгийн шинэ хуулийн 11 дүгээр зүйлд “Нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцох, гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсэхийг хэрэг үйлдэх үед дагаж мөрдөж байсан Эрүүгийн хуулийн дагуу шийдвэрлэх, гэмт хэргийн хор уршиг хэзээ илэрснээс үл хамааран тухайн гэмт хэрэг үйлдсэн үеийг гэмт хэрэг үйлдэгдсэн цаг хугацаанд тооцох” тухай, 12 дугаар зүйлд “үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэг тооцохгүй болсон, оногдуулах ялыг хөнгөрүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийг буцаан хэрэглэх, шинэ хуулиар тухайн гэмт хэрэгт оногдуулах ялын дээд хэмжээг багасгасан тохиолдолд урьд нь үүнээс дээгүүр ял шийтгүүлсэн этгээдийн ялыг шүүх уг дээд хэмжээнд нийцүүлэн хасах болон шинэ хуулиар тухайн гэмт хэрэгт оногдуулах ялын доод хэмжээг багасгасан тохиолдолд урьд нь үүнээс дээгүүр ял шийтгүүлсэн этгээдийн ялыг шүүх уг доод хэмжээнд нийцүүлэн хасах” талаар зохицуулалтыг тусгасан.

1987 оны Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан 51 гэмт хэргийг хуулиар гэмт хэрэгт тооцохгүй болсонтой холбогдуулан Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг баталсан. Энэ хуулиар Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх дараахь журам тогтоосон:

- Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцохгүй болсон хэрэгт 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө ял шийтгүүлсэн хүмүүсийг эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялаас нь чөлөөлөх;
- Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцогдохгүй болсон хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагааг хэрэгсэхгүй болгох;
- 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө ял шийтгүүлсэн этгээдэд шүүхээс оногдуулсан ял нь Эрүүгийн хуулийн зохих зүйл, хэсэг, заалтад зааснаар оногдуулж болох тухайн төрлийн ялын доод, дээд хэмжээнээс хүнд байвал уг ялыг шүүхийн магадлалаар Эрүүгийн хуулийн заалтад нийцүүлэх арга хэмжээ авах;
- Энэ хуулийн 1 дүгээр зүйлд зааснаар ялаас чөлөөлөгдсөн, түүнчлэн Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцохгүй болсон хэрэгт шилжүүлж ялаа эдэлж дууссан, хугацаанаас өмнө суллагдсан хүмүүсийг ялгүйд тооцох шийдвэр гарч хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан болно.

16 дугаар зүйл. Эрх зүйн этгээд байх эрхийг хүлээн зөвшөөрөх

Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлд “Хүн бүр эрх зүйн этгээд байна” гэж заасан. Эрх зүйн этгээд байна гэдэг бол Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хууль ёсоор оршин суугаа хүн бүрийн эрх, эрх чөлөөг хуулиар зохицуулж, хамгаалж байх үүргийг төрд оногдуулсан заалт юм. Энэ заалт нь хүн бүр төрснөөс эхлэн зарим тохиолдолд эхийн хэвлийд бий болсон үеэс эхлэн эрх зүйн чадвартай байхыг хүлээн зөвшөөрсөн явдал юм. Өмнөх илтгэлд энэ эрхийг Иргэний хуульд баталгаажуулсан тухай тодорхой дурдсан болно.

Түүнчлэн УИХ-аас баталсан “Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээгээр “Хүн бүр эрх зүйн этгээд байна гэсэн Үндсэн хуулийн зарчмыг хууль тогтоох үйл ажиллагаанд удирдлага болгох эрх зүйн орчин тодорхой хэмжээнд бүрдсэн байна” гэсэн дүгнэлт гарсан байна.

17 дугаар зүйл. Иргэний хувийн амьдрал, орон байрны байдал

Шинэчлэн найруулж буй Эрүүгийн хуульд Хүний орон байранд хууль бусаар нэвтрэн орох гэсэн бүлэгт “Оршин суугчийн зөвшөөрөлгүйгээр орон байранд нэвтэрч хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд халдсан бол нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Эрх бүхий албан тушаалтан хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж хүний орон байранд нэвтрэн орсон, нэгжлэг хийсэн, эд хөрөнгө хураан авсан бол дөрвөн мянга зургаан зуун далан тооцооны нэгжээс хорин дөрвөн мянган тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ “ гэж зааса. Орон байр гэдэгт хүн байнга, эсхүл түр амьдрахад зориулагдсан төрөл бүрийн орон сууц, байшин, гэр, урц, зочид буудал, амралт сувиллын газар, зуслангийн байр, майхан зэргийг ойлгоно.

Мөн хуулиар Хууль бусаар нэгжих, хураан авах, битүүмжлэх, Зөвшөөрөлгүй гэрэл зураг авах, дуу, дүрс бичлэг хийх заалтууд орсон ба “ Оршин суугчийн зөвшөөрөлгүйгээр орон байранд, эсхүл гадна талаас орон байрны доторх гэрэл зураг авсан, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийсэн бол нэг зуун тооцооны нэгжээс нэг мянга гурван зуун гучин тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар гэрийн хорионд байлгах, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заасан.

Хувь хүний нууцад халдах асуудлыг өмнөх хуульд зааснаас илүү тодорхой болгож “Хувь хүн нууцалж хамгаалсан, олон нийтэд ил болгоогүй баримт, мэдээллийг өөрийнх нь эсхүл эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр олж авсан, бусдад дамжуулсан бол дөрвөн зуун тооцооны нэгжээс дөрвөн мянга зургаан зуун далан тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар гэрийн хорионд байлгах, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэж шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд тусгасан.

18 дугаар зүйл: Шашин шүтэх, эс шүтэх эрх

Монгол Улсын Үндсэн хуулийн 9 дүгээр зүйлийн “З”-т “Төр, сүм хийдийн хоорондын харилцааг хуулиар зохицуулна” гэж заасан байдаг. “Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль”-иар Үндсэн хуулиар тунхагласан иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөөг хангах баталгааг тогтоох, төр, сүм хийдийн хоорондын харилцааг зохицуулахад оршино.

2008 оны эхний 6 сарын байдлаар Монгол Улсад бүртгэлтэй нийт 416 шашны байгууллага байсан бол 2015 оны 12 сарын байдлаар шашны 692 байгууллагууд бүртгэгдэн ажиллаж байна.

Үндсэн хууль болон Төр, сүм хийдийн харилцааны тухай хуульд зааснаар Монгол Улсын иргэн болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн шашин шүтэх, итгэл бишрэлээ чөлөөтэй сонгох бололцоог олгосон бөгөөд сүм хийд буюу шашны чиглэлийн хуулийн этгээдийг байгуулахад аливаа хязгаарлалт байхгүй.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулиар Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хэрэгжүүлэхэд саад учруулсан Хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулахаар сүрдүүлж шашны байгууллагын үйл ажиллагаа, эсхүл шашны зан үйл үйлдэхэд саад учруулсан бол нэг зуун тооцооны нэгжээс хоёр мянга гурван зуун дөчин тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр сараас зургаан сар хүртэл хугацаагаар гэрийн хорионд байлгах, эсхүл хоёр сараас зургаан сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд иргэний цэргийн албыг дүйцүүлэн хаахтай холбогдсон харилцааг зохицуулсан байдаг. Тус хуулийн 12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсэгт “Монгол Улсын 18-25 насны, цэргийн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэг бүхий иргэн шашин шүтлэг-ёс зүйн болон энэ хуульд заасан бусад шалтгаанаар цэргийн албыг дүйцүүлэн хааж болно. Цэргийн албыг дүйцүүлэн хаах хүсэлтэй иргэн онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын аврах анги, отряд, салбар Хилийн цэрэгт туслах хүчин болон хүмүүнлэгийн бусад байгууллагад алба хаана. Уг албыг хаах хугацаа 24 сар байна. Гамшгаас хамгаалах ажиллагааны хойшлуулшгүй арга хэмжээ, улсын хил хамгаалалтын зайлшгүй шаардлагыг харгалзан Засгийн газар энэхүү хугацааг 3 хүртэл сараар сунгаж болно” гэж заасан байдаг. Энэхүү зохицуулалтад иргэний шашин шүтлэг, ёс зүйн болон бусад шалтгаанаар цэргийн албыг дүйцүүлэн хаах харилцааг зохицуулсан.

Тус хуулинд цэргийн албыг дүйцүүлэн хаах журам, алба хаах иргэний тооны дээд хязгаарыг Засгийн газар тогтооно гэж заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 49 дүгээр тогтоолын хавсралтад заасан журмаар уг харилцааг зохицуулж байна.

19 дүгээр зүйл: Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16 дэх хэсэгт “Монгол Улсын иргэн нь үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөтэй” гэж заасан.

1998 онд Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль батлагдсан бөгөөд уг хуулийн 1 дүгээр зүйлд “... Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулах”, 2 дугаар зүйлд “Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглох”, 3 дугаар зүйлийн 1-д “Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй”, 4 дүгээр зүйлд “Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглох” тухай тус тус заасан.

Энэ хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд төрийн төв болон нутгийн захиргааны харьяалалд ажиллаж байсан бүх хэвлэл мэдээллийн хэрэгслийг татан буулгах, хувьчлах шийдвэрүүд гарч хэрэгжсэн бөгөөд хамгийн сүүлд 2005 онд “Олон

нийтийн радио телевизийн тухай” хууль батлагдаж уг мэдээллийн хэрэгслийг Засгийн газрын харъяалалаас гаргаж олон нийтийн статустай болгосон.

Гэхдээ өөрийн үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг зөвхөн хуулийн хүрээнд улсын аюулгүй байдал, нийгмийн хэв журам, эрүүл мэнд, ёс суртахуун, бусад хүний эрх, нэр төрийг хамгаалах ашиг сонирхолын үүднээс хязгаарлах бөгөөд энэхүү эрхээ эдлэхдээ бусдыг гүтгэсэн, доромжилсон, худал мэдээ тараасан этгээд хуульд заасан хариуцлага хүлээх тухай хуулийн зохицуулалт бий.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газраас хэвлэл, мэдээллийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох тодорхой зорилтуудыг үйл ажиллагааныхаа хөтөлбөрт тусган ажиллаж байна. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан “мэдээлэл хайх, хүлээн авах” эрхийг хуулиар баталгаажуулах зорилгоор Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг боловсруулж байна. Уг хуулиар төрийн болон хувь хүний нууцад хамаарахаас бусад мэдээллийг өгөх журмыг тогтоох болон сэтгүүлчдийн мэдээллийн эх сурвалжийг нууцлах, хамгаалах, мэдээлэл олж авах боломжийг нэмэгдүүлэх харилцааг зохицуулах юм.

20 дугаар зүйл. Дайныг сурталчлах, арьсны өнгөөр ялгаварлан гадуурхахыг хориглох

Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улс олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна” гэж заасан. Монгол Улсын Их Хурал 1994 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 56 дугаар тогтоолоороо тус улсын “Гадаад бодлогын үзэл баримтлал”-ыг баталсан. Уг үзэл баримтлалд заасны дагуу Монгол Улс нь энхийг эрхэмлэж, бүх улс оронтой найрсаг харилцаатай байж, цэргийн аливаа эвсэл, бүлэглэлд үл нэгдэх бодлого баримталдаг. Шинэчилсэн Эрүүгийн хуулиар Үндэсний эв нэгдлийг бусниулах “Хүмүүсийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, шашны номлол, үзэл бодлоор дайсагнуулах, эвдрэлцүүлэх, салан тусгаарлахыг ухуулсан, уриалсан, ялгаварлан гадуурхсан, хүчирхийлсэн, эрхийг нь хязгаарласан эсхүл давуу байдал тогтоосон үйлдлийг зохион байгуулсан бол хорин дөрвөн мянган тооцооны нэгжээс жаран мянган тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэсэн. Монгол Улсын Үндсэн хуулинд хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхахыг хориглож, өөр өөр зан заншил, хэл, соёл бүхий үндэстний цөөнхийг эх хэлээрээ суралцах, харилцах, соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах эрхийг нь тунхагласан нь тус улсад оршин суугаа үндэстнүүдийн эв нэгдлийг хангахад чухал үүрэгтэй.

21 дүгээр зүйл. Тайван жагсаал цуглаан хийх эрх

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар иргэд тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал цуглаан хийх журмыг 1994 онд батлагдсан хуулиар зохицуулсан. Уг хуулийн зорилго нь тайван жагсаал цуглаан хийх иргэдийн Үндсэн хуулийн эрх чөлөөг баталгаажуулах, жагсаал цуглаан хийх журмыг тогтоох, уул арга хэмжээний үед нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад орших бөгөөд энэ тухай өмнөх 4 дэх илтгэлт тодорхой дурдсан.

Иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх эрхийн хэрэгжилт нь тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй салшгүй холбоотой, эдгээр эрхүүд нь нэг нь нөгөөгүйгээр байх боломжгүй, хоорондоо салшгүй нягт уялдаатай байдгаараа онцлогтой.

Иймд Засгийн газрын зүгээс нийгмийн харилцаанд гарсан өөрчлөлтийг үндэслэл болгон гудамж, талбайд жагсаал цуглаан зохион байгуулахад зөвшөөрөл олгодог хуулийн зохицуулалтыг өөрчилж, бүртгэлийн зохицуулалттай болгох асуудлаар “Жагсаал цуглаан хийх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан УИХ-д өргөн барьсан бөгөөд УИХ-аас 2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр хуулийн төслийг баталсан юм.

22 дугаар зүйл. Эвлэлдэн нэгдэх эрх

Монгол Улсад иргэний нийгмийн байгууллага, төлөөллийг төрийн бус байгууллагууд гүйцэтгэдэг бөгөөд 1997 онд батлагдсан “Төрийн бус байгууллагын тухай хууль”-ийн дагуу байгуулагдан, үйл ажиллагаагаа явуулдаг. Сайн дураар эвлэлдэн нэгдэх эрхийн үндсэн дээр, гишүүддээ болон нийгэмд үйлчлэх үүрэгтэйгээр байгуулагдах, улсын бүртгэлийн газарт бүртгүүлснээр үйл ажиллагаа явуулах, ашгийн бус ажиллагаа эрхлэх учир татвар төлөхөөс чөлөөлөгдөх зэрэг эрх хэмжээг нь тогтоосон байдаг. Өнөөдрийн байдлаар Монгол Улсад 20,862 төрийн бус байгууллага янз бүрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Улсын төрийн намуудын тухай хуулийг 2005 онд шинэчлэн баталсан бөгөөд энэ хуулиар иргэд улс төрийн нам байгуулах, намыг бүртгэх үйл ажиллагааг нь зогсоох, дуусгавар болгохтой холбогдсон зарчим журмыг тогтоосон.

Нам нь Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу нийгмийн ашиг сонирхол болон хувийн үзэл бодол, улс төрийн үйл ажиллагаа явуулах зорилгын үүднээс сайн дураараа эвлэлдсэн Монгол Улсын иргэдийн нэгдэл мөн гэж Улс төрийн намын тухай хуульд заасан. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7.1.6-д “Улс төрийн намыг Улсын Дээд Шүүх бүртгэнэ” гэж заасны дагуу Улсын Дээд Шүүх бүртгэж гэрчилгээ олгож байна. Өнөөдрийн байдлаар 24 нам улсын бүртгэлд бүртгэгдэж үйл ажиллагаагаа явуулж байна.

23 дугаар зүйл Төрөөс гэр бүлийг хамгаалах

Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 11-дэх хэсэгт “...Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална...” гэж заасан. Энэ заалтыг Гэр бүлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид тусган хэрэгжүүлж байна.

Цагдаагийн байгууллага гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх нэгж байгуулах асуудлыг судалж, Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар тус газрын бүтцэд “Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтэс”-ийг 32 орон тоотой байгуулж, үйл ажиллагааг нь жигдрүүлсэн.

Мөн Нийслэлийн цагдаагийн газрын Хүүхэд хамгаалал, хаяг тогтоох төвийг татан буулгаж, үйл ажиллагааны чиглэлийг өөрчилж, гэр бүлийн хүчирхийлэлд өртөж хохирсон иргэдийг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий “Түр хамгаалах байр” болгон 2014 оны 02 дугаар сарын 28-ны өдрөөс үйл ажиллагааг нь эхлүүлсэн.

“Түр хамгаалах байр” нь 70122602, 93022570, 94301666, 89535007, 96549395, 107 дугаарын утсаар иргэдээс 24 цагаар мэдээлэл хүлээн авч, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдийг хүлээн авч хамгаалалтад авах, мэргэжлийн сэтгэл зүйч, нийгмийн ажилтан нар зөвлөгөө өгөх, бусад шаардлагатай үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

Түр хамгаалах байр байгуулагдсанаас хойш 2015 оны 4 дүгээр сарын байдлаар 287 гэр бүлийн нийт 456 үйлчлүүлэгчийг хүлээн авснаас насанд хүрсэн эрэгтэй хүн 2, эмэгтэй хүн 144, эрэгтэй хүүхэд 188, эмэгтэй хүүхэд 122 байна.

Цаашид гэр бүлийн хүчирхийлэлд өртөж хохирсон иргэдийг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх “Түр хамгаалах байр”-ыг орон нутагт байгуулах асуудлыг судлан шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.

2013 оноос аймаг, нийслэлд иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх төв байгуулагдаж, хүчирхийлэлд өртсөн иргэд хууль эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл, өмгөөллийн туслалцаа авах нөхцөл бололцоог хангах ажлыг цагдаагийн байгууллага нутаг дэвсгэрийн төр, захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байна. Мөн орон нутгийн цагдаагийн газар, хэлтсүүд “Дэлхийн зөн-Монгол” Олон улсын байгууллагын салбар байгууллагуудтай хамтран гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх чиглэлээр “Итгэлийн утас”-ыг 2012 оноос эхлэн ажиллуулж байна.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдыг хамгаалах эрх зүйн орчинг боловсронгуй болгон сайжруулах зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачлан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгийг Улсын Их Хуралд өргөн бариад байна.

Түүнчлэн Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд гэр бүлийн хүчирхийллийн үед ажиллах үйл ажиллагааг нарийвчлан журамласан зохицуулалтыг тусгасан.

Цагдаагийн байгууллагаас гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлж, таслан зогсоох, илрүүлэх, хохирогчийг түр хамгаалалтад авах, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх журам”-ыг шинэчлэн боловсруулж батлуулан мөрдөж байна.

24 дүгээр зүйл. Төр, нийгмээс хүүхдийн эрхийг хамгаалах

Монгол Улсын Ерөнхий сайдаар ахлуулсан Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл хүүхэд бүрийг үл хайхрах, хүчирхийлэх, хүүхдийн хөдөлмөрийг мөлжих явдлаас сэргийлэх, хамгаалах тогтолцоог хөгжүүлэх зорилт бүхий Хүүхэд хамгааллыг бэхжүүлэх стратеги (2010-2015)-ийн бодлогын баримт бичгийг 2010 онд батлан, түүнийг хэрэгжүүлэхээр төлөвлөгөө гарган ажиллаж байна. Стратегийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2012 оноос эхлэн жилд дунджаар 400-500 сая төгрөгийг Засгийн газраас олгож байна.

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үндэсний хөтөлбөрийг 2011 онд, Хүүхдийн хөгжлийн шаталсан хөтөлбөрийг 2013 онд тус тус батлан хэрэгжүүлж байна. Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй нийт 428 хуулийн 60 орчимд нь хүүхэд, хүүхдийн эрхийн холбогдолтой 350 гаруй заалт байдаг. Хүүхдийн эрхийн тухай конвенцийн үзэл санаанд нийцүүлэн хүүхдийн талаарх үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгох зорилгоор Хүүхдийн эрхийн тухай болон Хүүхэд хамгааллын тухай хуулийн төслүүдийг эцэслэн боловсруулсан бөгөөд одоо батлуулахаар ажиллаж байна.

Эдгээр хуулийн төсөлд хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг бууруулах зохицуулалт, Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн¹ найруулгын төсөлд 15 насанд хүрээгүй хүнээр хөдөлмөр эрхлүүлэхийг хориглох зохицуулалт, Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хүүхэд үрчлэлийн эрх зүйн зохицуулалтыг холбогдох олон улсын гэрээнд нийцүүлэн тусгасан болно.

Монгол Улс Хүүхдийн эрхийн конвенцийн Мэдээлэл хүргүүлэх журмын тухай нэмэлт протоколыг соёрхон батлах чиглэлээр ажиллаж байна. Түүнчлэн ХҮЭК Хүүхдээс гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах, хуваарилах, шийдвэрлэх журмыг 2012 онд баталсан. Хүүхдийн эрхийн асуудлаар хүүхэд болон насанд хүрэгчдээс ХЭҮК-т гаргасан нийт өргөдөл, гомдлоос 2010 онд 6, 2011 онд 10, 2012 онд 10, 2013 онд 12-ыг нь бүрэн шийдвэрлэсэн байна.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, бие махбодийн далд шийтгэл тодорхой хэмжээнд байгаа бөгөөд ийм нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, бүртгэх, хамгаалах үйл ажиллагааг нэгдсэн системд оруулах зорилгоор хүүхдийн тусламжийн утасны үйлчилгээ үзүүлж байна. Хүүхдийн тусламжийн утас 108 нь 24 цагийн /үнэ төлбөргүй/ үйлчилгээтэй бөгөөд хүүхдийн эрхийн зөрчлийн тухай иргэд, байгууллагын мэдээллийг нарийвчлан бүртгэж, эрсдлийн үнэлгээ хийж байна. Тус утас нь 2013 оны жилийн эцсийн байдлаар 42946 зорилтод дуудлага хүлээн авч, үйлчилсэн байна. Хүүхдийн тусламжийн утас нь Хүүхдийн байгууллагын чиг үүргийн дагуу кейст тулгуурлан үзүүлэх үйлчилгээний тогтолцоог бий болгох үндсэн үйл ажиллагаа юм. Уг төслийн санхүүгийн дэмжлэгийг 2014 оны 06 сарын 01-нээс эхлэн 3 жилийн хугацаанд Мобиком, Дэлхийн зөн ОУБ хамтран үзүүлж байна.

Үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага MNS6264:2011 стандартыг 2012 оноос мөрдөн хэрэгжүүлснээр уралдаанч хүүхдийн эрхийг хамгаалах тал дээр ахиц гарсан боловч цаашид анхаарах асуудал байсаар байна.

Засгийн газраас 2011 онд баталсан Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах 2012-2016 оны үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрийг Олон улсын хөдөлмөрийн байгууллагын дэмжлэгтэй боловсруулсан бөгөөд хөтөлбөрт хүүхдийн хөдөлмөрийг зохицуулах хууль тогтоомжийг нэгдэн орсон олон улсын гэрээний зарчимд нийцүүлэх, энэ чиглэлийн хууль сахиулах байгууллагын чадавхийг сайжруулах, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрт өртсөн хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах үндсэн зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна. 2013 оны байдлаар 93968 хүүхэд хөдөлмөр эрхэлж байгаагийн 10398 хүүхэд хүнд хэлбэрийн хөдөлмөр эрхэлж байна.

Мэргэшсэн хөдөлмөрийн байцаагчдыг нэмэгдүүлэх замаар хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн хяналтыг дээшлүүлэх зорилгоор 2009 онд Хүүхдийн хөдөлмөрт хийх хяналт шалгалтын аргачлалыг боловсруулж улсын хэмжээнд хэрэгжүүлэхийг даалгасан. Энэ аргачлалын дагуу хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчид аж ахуйн нэгж байгууллагад 2012 онд хийсэн шалгалтаар 1012 хүүхэд хөдөлмөр эрхэлж байгааг тогтоож, хууль журмын дагуу холбогдох арга хэмжээ авсан.

Хөдөлмөр эрхэлж буй хүүхдэд тусгайлан чиглэсэн нийгмийн үйлчилгээний хүртээмж хязгаарлагдмал байна. Хөдөлмөр эрхэлж буй хүүхдэд өдрийн үйлчилгээ үзүүлдэг төрийн

¹ Хуулийн төслийг анхдагч болон шинэчилсэн найруулга гэж ангилдаг. Нийгмийн тодорхой харилцааг анх удаа хуульчлан зохицуулах бол тухайн хуулийн төслийг анхдагч, харин харилцааг зохицуулж байсан хуулийг өөрчлөх, ингэхдээ хуулийн зохицуулалтын 50 болон түүнээс дээш хувьд нь өөрчлөлт оруулах тохиолдолд тухайн хуулийн төслийг шинэчилсэн найруулга гэж ойлгодог.

бус байгууллагын төв 2010 оноос нийслэлд ажиллаж эхэлсэн ч төсөв, санхүүгийн хомсдолоос шалтгаалан өнөөгийн байдлаар цөөн хүүхдэд хүрч үйлчилж байна. Хөдөлмөрийн төв бирж “Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөр”-ийн хүрээнд 2013-2014 онд 16-18 насны 81 хүүхдийг тэдгээрийн хүсэлтийн үндсэн дээр мэргэжлийн сургалтад хамруулсан. Түүнчлэн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн газар 2012-2013 онд сайн дураараа хөдөлмөр эрхлэгч 5-17 насны 180 хүүхдийг нийгэмшүүлэх сургалтад хамруулсан байна.

25 дугаар зүйл. Төрийг удирдах хэрэгт оролцох эрх

Парламентад нийт 76 гишүүнээс 11 эмэгтэй гишүүн сонгогдохын зэрэгцээ эмэгтэй гишүүдийн бүлэг байгуулан ажиллаж байна.

Улс төрийн намууд дүрмэндээ намын шийдвэр гаргах удирдах байгууллагад эмэгтэйчүүдийн төлөөллийг 20-40 хувь байлгахаар тусган ажиллаж байна. Тухайлбал: Ардчилсан нам Үндэсний зөвлөлдөх хорооны 154 гишүүны 51 нь суудал эмэгтэй, Монгол Ардын нам Бага хурлын гишүүд болон удирдах зөвлөлдөө 20 хувь нь эмэгтэй, Иргэний Зориг ногоон нам Удирдах зөвлөлийн гишүүдийн 50 хувь нь эмэгтэй байхаар тус тус квотыг тусгасан байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хуулийн 10 дугаар зүйлд төрийн болон орон нутаг, аж ахуй нэгж байгууллагуудын удирдах албан тушаалд хүйсийн тэгш эрхийг хангах квотын заалтуудыг тус тус тусган хэрэгжүүлж мониторинг хийн ажиллаж байна.

УИХ-аас улс төрийн намуудын тухай хуулийг шинэчлэн боловсруулж намын санхүүжилт, ил тод байдлыг хангах, Сонгуулийн нэгдсэн хуулийн төсөлд сонгуульд өрсөлдөх санхүүжилт, хэвлэл мэдээллийн хязгаарлалт, намын жагсаалтаар сонгогдох нэр дэвшигчдийн жагсаалтанд эмэгтэй нэр дэвшигчдийг жагсаалтаар цахилгаан товчны зарчмаар эрэмбэлэх зэрэг нэмэлт өөрчлөлтийг оруулахаар ажлын хэсэгтэй хамтран ажиллаж байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйлд төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн удирдлагын байгууллагад эмэгтэйчүүдийн төлөөллийг бүх түвшинд 15-40 хувь байхаар ангилан тогтоосон.

26 дугаар зүйл. Ялгаварлан гадуурхах явдлыг хориглох

Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “тус улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш байна гэж заасан бөгөөд тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэний эрх, үүргийг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон уул иргэнийг харьяалсан улстай байгуулсан гэрээгээр тогтоох бөгөөд олон улсын гэрээгээр гадаадын иргэний эрх үүргийг тодорхойлохдоо уул иргэнийг харьяалсан улстай энэ талаар харилцан адил байх зарчим баримталдаг.

Гадаадын иргэн, харьяалалгүй хүний хувьд тэдний зарим улс төрийн эрхийг хязгаарлах тохиолдол бий. Тухайлбал, шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох, төрийн байгууллагад сонгох, сонгогдох, ард нийтийн санал асуулгад оролцох, төрийн албан хаагчаар ажиллах, улс төрийн үйл ажиллагаа явуулах байгууллага байгуулах, түүнд элсэн орох, бусад хэлбэрээр улс төрийн аливаа үйл ажиллагаа явуулах, Засгийн газрын зөвшөөрөлгүйгээр улсын онц

чухал объект гэж хуулиар тогтоогдсон газарт ажиллахыг тус тус хориглосон /Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйл/.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харуул хамгаалалтын албан хаагчдын ажлын байрны орчны буюу эд хогшил, техник хэрэгсэл, ялтан, хоригдсон этгээдийг олон нийтээс тусгаарлах, тэднээс үйлдэж болзошгүй гэмт үйлдэл, халдлагаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, түүнчлэн тэдний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий хорих байгууллагын албан хаагчдын өдөр тутам үүрэг гүйцэтгэх ажлын байранд тавигдах нийтлэг шаардлага, шаардлагатай техник хэрэгслийн шалгуур үзүүлэлтийг тогтоосон түүнчлэн хоригдогч, албан хаагчдын хоорондын харилцааны хэм хэмжээг тодорхойлсон дараах стандартуудыг боловсруулан батлуулж үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллаж байна.

1."Хорих байгууллагын албан хаагчдын үйл ажиллагааны стандарт" /CS 11-0233:2013/

2."Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харуул хамгаалалтын албан хаагчдын ажлын байрны орчны буюу эд хогшил, техник хэрэгслийн стандарт" /CS 11-0234:2013/

3."Хоригдогсдын эрхийг хангахад чиглэсэн цагдан хорих, хорих ял эдлүүлэх ажиллагааны стандарт" /CS 11-0238-2013/

Уг стандартын төслийг Улсын ерөнхий прокурорын газар, Хүний эрхийн үндэсний комисс, "Эмнэсти интэрнэшнл" зэрэг байгууллагад хүргүүлэн, санал дүгнэлтийг нь авч боловсруулсан.

4."ТГГ-ын нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандарт" /CS 11-0235:2013/

5."Цагдан хорих төвийн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандарт" /CS 11-0237:2013/

6."Тусгай мэргэжлийн сүрьеэгийн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандарт" /CS 11-0236:2013/

7."Хорих ангийн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандарт" /CS 11-0234:2013/

8."Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны сэтгэл зүйчийн өрөөний стандарт"-ыг баталж, хорих анги, албанд хүргүүлсэн.

Орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр:

Өвөрхангай аймгийн Хархорин дахь шийдвэр гүйцэтгэх албаны цагдан хорих байрыг хорих 423 дугаар ангийн хамгаалалтын бүсэд шилжүүлэн байршуулсан.

Булган аймаг дахь Шийдвэр гүйцэтгэх албаны цагдан хорих байрыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дотоод орлогын эх үүсвэрээр 272 сая төгрөгийн өртөг бүхий 50 хоригдогчийн багтаамжтай, 16 хорих өрөөтэй цагдан хорих байрыг барьж ашиглалтанд оруулсан. Мөн Орхон аймаг дахь Шийдвэр гүйцэтгэх албаны 250 хоригдогчийн багтаамжтай цагдан хорих, ял эдлүүлэх байрыг ашиглалтанд оруулсан.

2014 оны 10 дугаар сарын 03-ны байдлаар Дорнод, Увс, Дундговь аймаг дахь шийдвэр гүйцэтгэх албаны цагдан хорих байрны барилгын ажил эхлээд 40-45 хувьтай үргэлжилж байгаа болно.

27 дугаар зүйл. Цөөнхийн эрх

Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 2-т "Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна." гэж заасан нь Монгол Улс аливаа хэлбэрийн ялгаварлан

гадуурхалыг хориглосны илэрхийлэл юм. Иймээс ч дээрх Үндсэн хуулийн үзэл санаа нийгмийн харилцааг зохицуулах гол хуулиудад тусгалаа олсон байдаг.

Сурч боловсрох эрхийн тухайд Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 2-т “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна” гэж заажээ. Мөн 16 дугаар зүйлийн 7-д “Сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно. Иргэд төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулан ажиллуулж болно” гэж заасан нь хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнхийн эх хэлээрээ суралцах, харилцах, соёл урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах эрхийг хөндөхгүй юм.

2015 оны байдлаар Монгол Улсад төрлөөр устгах, апартеид, арьс үндсээр алагчилсан тохиолдол бүртгэгдээгүй байна.
